

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2021 ОНЫ 03 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2020 оны 03 дугаар сарын 31

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2021 оны 03 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Ажлын албанаас 2021 оны 3 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 03 дугаар хуралдаан 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр цахимаар хуралдлаа.

Тэргүүлэгчдийн 03 дугаар хуралдаанаар:-

1.Аймгийн хөгжлийн сангийн тухай мэдээлэл, 2021 оны тэргүүлэх чиглэл, хөгжлийн сангийн 2021 оны зардал батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн хөгжлийн сангийн тэргүүлэх чиглэлийг “Ковид-19” цар тахлаас урьдчилан, сэргийлэх нөөцийн бэлэн байдлыг хангах, Инноваци, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, “Нэг сум-нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдаа, Цаг үеийн байдал, өвөлжилт хаваржилт, Байгаль орчин гэсэн 6 чиглэлийн хүрээнд 13 төсөл хэрэгжүүлэхээр, 2021 оны үйл ажиллагааны зардлыг нь 22592.0 мянган төгрөгөөр тус тус батлав.

2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны “Жишиг үнэлгээ тогтоох тухай” 53-р тогтоолыг хүчингүй болгох тухай асуудлыг хэлэлцээд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хуулиуд 2018 оны 06 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль хүчингүй болсон тул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Жишиг үнэлгээ, тогтоох тухай” 53 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцов. Тус тогтоолыг хүчингүй болсонтой холбогдуулан тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд зөвлөв.

3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2019-2020 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцээд 96.87 хувьтай хэрэгжсэн тул “Үр дүнтэй” гэж дүгнэв.

4.Аймгийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний төслийг боловсруулсан талаарх мэдээллийг хэлэлцээд “Аймгийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”-г 39 хэрэгжүүлэх арга хэмжээтэй батлав.

5.Төрийн дээд одон медальд уламжлах тухай асуудлыг хэлэлцээд “Хөдөлмөрийн баатар” цолоор 1, “Ардын жүжигчин” -2, **“Гавьяат эдийн засагч” - 1, “Гавьяат эмч” 3, “Гавьяат холбоочин”- 1, “ Гавьяат багш”-3, “Соёлын гавьяат зүтгэлтэн” цолоор 1, “Сүхбаатарын одон”-оор 1, “Цэргийн гавьяаны одон”-оор-1, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор 11, “Алтан гадас одон”-оор 39, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар 31, нийт 96 иргэнийг шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.**

6. Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны тухай мэдээллийг хэлэлцээд салбарын хүний нөөцийн судалгаанд үндэслэн нэн шаардлагатай мэргэжлээр Соёл Урлагийн Их сургуульд суралцуулах албан хаагчдыг сонгон, гэрээ байгуулж сургалтын зардлыг төсөвт тусгах замаар тодорхой дэмжлэг үзүүлж, цаашид тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангахад орон нутгаас бодлогоор дэмжиж соёлын байгууллагыг мэргэжилтэй ажилтнаар хангах дэс дараатай арга хэмжээ авах, соёл, урлагийн байгууллагын соёл, албан хаагчийн ёс зүй, эерэг харилцаа хандлагыг төлөвшүүлж, үйл ажиллагааны чанарыг сайжруулан, Соёл, урлагийг дэмжих сангийн санхүүжилтээр шаардлагад нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, иргэд олон нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэхэд чиглүүлэх, COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх хөл хорионы дэглэмийн үеэр иргэдэд соёл, урлагийн үйлчилгээг цахимаар тасралтгүй хүргэх, аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаатай соёлын үйлчилгээг холбож тасралтгүй хөгжүүлэх чиглэлээр Монгол туургатан театрын менежментийг сайжруулж, **аялал жуулчлалын эвент арга хэмжээ, контент бий**

болгох, хүүхдэд зориулсан уран бүтээл, шинээр туурвисан болон шинэчилсэн уран бүтээлийг хүн амын бүхий л давхаргад хүргэх, **Монгол туургатан театр, соёлын төвүүд нь** үйл ажиллагааны орлогоо нэмэгдүүлэх асуудлаар бизнес менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, аймаг, сумын номын сангийн фондыг нэмэгдүүлж, ном унших арга зүй эзэмшүүлэх, өсвөр насны хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх, үндэсний хэл, соёл, уламжлал, зан заншлаас суралцах, өвлүүлэн хөгжүүлэх чиглэлээр соён гэгээрлийн цогц ажлыг зохион байгуулах, **Музейн соёлын өвийг байнга баяжуулж, үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлэн иргэд, хүүхэд, залуучуудад эх нутгаараа бахархах нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах**, соёлын салбарын боловсон хүчний мэдлэг чадавхыг дээшлүүлэн, аймгийн Боловсролын газрын соёлын асуудал хариуцсан мэргэжилтнийг үүрэгжүүлж, ажлын үр дүнг сайжруулах, Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойд зориулсан арга хэмжээний бэлтгэл зохион байгуулалтыг хангаж ажиллах, Соёл, урлагийн байгууллагуудын орлого, зарлага, хөрөнгө оруулалтын үр дүнг жил бүр тооцож, хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

7. Хуралдааны тов тогтоож хэлэлцэх асуудал батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус Нэгдүгээр Хуралдааныг 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн “Даваа” гарагт аймгийн Засаг даргын Тамгын газрын Хуралдааны танхимд цахимаар хуралдуулахаар шийдвэрлэн тус хуралдаанаар Сэргэлэн, Алтанбулаг сумдын зарим газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаар санал уламжлах тухай асуудлыг хэлэлцүүлэхээр тогтов.

8.Сэргэлэн, Алтанбулаг сумдын зарим газар нутгийг улсын тусгай хэрэгцээнд авах талаар санал уламжлах тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 03 дугаар Хуралдаанаар 8 асуудал хэлэлцэж 7 тогтоол батлаж хуралдааны 1 тэмдэглэлээр үүрэг өгөв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит бус 1-р хуралдаан 2021 оны 03-р сарын 22-ны өдөр 82.9 хувийн ирцтэйгээр цахимаар хуралдлаа.

Тэргүүлэгчдийн ээлжит бус 1 дүгээр хуралдаанаар:-

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн “Хуралдааны тов тогтоож, хэлэлцэх асуудал батлах тухай” 21-р тогтоолын 1 дүгээр заалтын “2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр” гэснийг “2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 14 цагт цахимаар” хуралдуулахаар 2021 оны 21-р тогтоолын 1 дүгээр заалтад өөрчлөлт оруулав.

2. Сэргэлэн, Алтанбулаг сумдын зарим газар нутгийг улсын тусгай хэрэгцээнд авах талаар санал уламжлах тухай асуудалд Хурлын Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд тус асуудалд Сэргэлэн сумын ИТХ хуралдаж саналаа ирүүлээгүй тул Алтанбулаг сумын зарим газар нутгийг улсын тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг Хурлын хуралдаанд шилжүүлэв.

Аймгийн ИТХ-ын ээлжит бус 1 дүгээр Хуралдаан 2021 оны 03-р сарын 23-ны өдөр цахимаар хуралдлаа.

Аймгийн ИТХ-ын ээлжит бус 1 дүгээр хуралдаанаар:-

1. Алтанбулаг сумын зарим газрыг улсын тусгай хэрэгцээнд авах санал уламжлах тухай аймгийн Засаг даргын мэдээлэл, тэдгээрт Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус Нэгдүгээр хуралдаанаар хэлэлцээд Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/813 дугаар “Зарим газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” албан бичигт дурьдагдсан асуудлыг хэлэлцэв.

Мөн аймгийн ИТХ-ын ээлжит бус 1-р хуралдаанаар хэлэлцэгдэж батлагдан гарсан тогтоол, холбогдох материалыг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг үүрэг болгов.

Аймгийн ИТХ-ын Ажлын албаны хүрээнд:

3 дугаар сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 25 албан бичиг ирснийг бүртгэн авч хариу хүргүүлэх шаардлагатай 2 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын даргад хандан иргэдээс 7 өргөдөл ирснээс 1 өргөдлийг Зуунмод сумын ЗДТГ-т шилжүүлж, 4 өргөдлийн хариуг хүргүүлэн ажилласанаас 2 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.

Аймгийн ИТХ-ын дарга, Хурлын Ажлын албанаас УИХ-ын гишүүд, Ерөнхийлөгчийн тамгын газар, салбарын яамдад болон холбогдох албан байгууллагад 25 бичгийг гарган хүргүүлж ажиллалаа.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба нь УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөлтэй хамтран 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 04 дүгээр сарын 12-ны өдрүүдэд 27 сумын ИТХ-ын төлөөлөгч нарт сургалт зохион байгуулахаар хөтөлбөр, хуваарийг батлан ажиллаж байна.

Сургалтыг 27 суманд танхимаар зохион байгуулахаар төлөвлөсөн ч аймгийн төв Зуунмод суманд короновируст цар тахал бүртгэгдэж өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Алтанбулаг, Аргалант, Баянцагаан, Борнуур, Батсүмбэр, Сүмбэр, Баян, Баянжаргалан, Архуст, Мөнгөнморьт сумдад 03 дугаар сарын 15-аас 03-р сарын 29-ний өдрүүдэд цахимаар зохион байгууллаа.

Тус сургалтад сумын ИТХ-ын дарга, Нарийн бичгийн дарга, Төлөөлөгчдийн 90 гаруй хувийг хамруулж, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Захиргааны ерөнхий хууль, орон нутгийн төсвийн удирдлага, байгаль орчны төлөвлөлт, санхүүжилт сэдвээр явууллаа.

Энэхүү сургалт нь орон нутгийн сонгуулийн үр дүнгээр шинээр сонгогдсон Төлөөлөгч нарт хууль эрх зүйн мэдлэг олгох, тэднийг чадавхжуулах, сумын ИТХ-д хуулиар олгогдсон эрх үүргийг хэрэгжүүлэхэд ИТХ-ын төлөөлөгчдөд шаардлагатай суурь мэдлэгийг олгох, практикт гарч байгаа хүндрэлийг шийдвэрлэх арга замыг хэлэлцэх арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор хийгдэж байна.

Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас Төв аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүнээр оролцох хүсэлт ирүүлсэн 17 иргэний материал хүлээн авч, шаардлага хангасан 16 иргэнд санал авах ажиллагааг 03-р сарын 03-аас 04-р сарын 02-ны өдөр хүртэл цахим хэлбэрээр зохион байгуулж байна.

Авлигатай тэмцэх газраас аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нийтийн албан тушаалтныг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, чадавхжуулах замаар авлигаас урьдчилан сэргийлэх сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14 цагт цахимаар зохион байгууллаа. Сургалтад аймаг, сумын нийт 313 Төлөөлөгч хамрагдаж авлигын эсрэг хууль, тогтоомжийн талаарх мэдлэг, чадвараа дээшлүүлэв.

Сургалтын дараа тус аймгийн Борнуур сумын ИТХ-ын Төлөөлөгчид нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахаа илэрхийлж, иргэд олон нийтэд хандаж “Мэдэгдэл” гаргалаа.

2021 оны 03-р сарын 01-ний “Эх орончдын өдөр”-ийг тохиолдуулан Ардын Засгийн газрын анхны Ерөнхий сайд, Төр нийгмийн нэрт зүтгэлтэн Д.Бодоогийн хөшөөнд цэцэг өргөлөө. Цэцэг өргөх ёслолд УИХ-ын гишүүн Ж.Батжаргал, Аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, Засаг дарга Д.Мөнхбаатар, Засаг даргын орлогч Г.Сурмаа, Ц.Бумбуян, Зуунмод хотын захирагч Ч.Сарангэрэл нар болон зарим хэлтэс, агентлагийн дарга нар, төрийн албан хаагчид оролцов. Энэ үеэр Зуунмод сумын ИТХ-аас Төв цэцэрлэгт хүрээлэнг Ардын Засгийн Анхны Ерөнхий сайд Д.Бодоогийн нэрэмжит болгон зарласан юм.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарын нэгдсэн уулзалт, семинарыг 3 дугаар сарын 11, 12-ны өдөр зохион байгуулагдлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд яам болон аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын баримталж ажиллах чиглэлийн талаар нэгдсэн ойлголт өгч салбар салбарын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлаар мэдээлэл өгсөн байна.

Мөн аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэнгийн санаачлагаар “Өрхийн тариалан бизнес хөгжил” ТББ Төв аймгийн Баянчандмань, Баянцогт зэрэг сумдын 100 өрхөд тус бүр хүнсний болон малын тэжээлийн тусламжийн багц олгох ажлыг зохион байгуулав.

Халдварт цар тахал корона вирусын халдвар Зуунмод суманд бүртгэгдсэнтэй холбогдуулан “Нэг өрх-Нэг шинжилгээ”-г 2 өдөр зохион байгуулж Зуунмод сумын 4489 иргэн хамрагдаж 6 багт 20 шинжилгээний цэг гарч 146 төрийн албан хаагч шинжилгээ авах цэгүүдэд ажилласнаас аймгийн ИТХ-ын Ажлын албаны ажилтнууд мөн ажилласан.

Монгол улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан Төв аймгийн онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагаа, аймгийн Онцгой комиссын үйл ажиллагаа болон мал аж ахуйн хаваржилт, тариалалтын нөхцөл байдалтай танилцлаа. Мөн улсын Онцгой комиссоос Аймгийн Онцгой Комисст шаардлагатай ариутгалын бодис, хамгаалах хувцас зэрэг эд материалуудыг гардуулан өглөө.

Энэ үеэр аймгийн онцгой комиссоос нэн тэргүүнд PCR шинжилгээний лаборатори болон Зуунмод сумын 18-аас дээш насны 11 мянга орчим иргэдийг Корона вирусийн вакцинжуулалтад яаралтай хамруулах хүсэлтэй байгаагаа илэрхийлж уламжилсан юм.

Төв аймагт эхний ээлжид БНХАУ-ын Синофарм үйлдвэрийн 1000 тун вакцин ирснийг 3-р сарын 27-оос эхлэн Эмнэлгийн мэргэжилтнүүд, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналт, Цагдаагийн албан хаагчид, Аймгийн онцгой комиссын гишүүд, Аймгийн стратег бүхий байгууллагын албан хаагчид дархлаажуулалтад хамруулж эхлээд байна.

Аймгийн ИТХ-ын Ажлын албанд Лүн сумын ИТХ 3-р сарын тайлангаа ирүүлж ажилласан байна.

Лүн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 03 дугаар хуралдаан 03-р сарын 19-ний өдөр хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцсэн байна. Үүнд:

1. Сумын Засаг даргын орлогчийн мэдээлэл

2. “Сонгодог урлаг -3” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэлт өгөх тухай

3. “Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр”, төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж дүгнэлт өгөх тухай

4. Шагналд тодорхойлох тухай

5. Сонгуулийн сурталчилгааны байршил тогтоох тухай

6. Ажлын хэсэг байгуулах тухай /Иргэний өргөдлийн мөрөөр/

7. Ажлын хэсэг байгуулах тухай / тогтоолын хэрэгжилт /

8. Төлөвлөгөө батлах тухай зэрэг нийт 8 асуудал хэлэлцэж 7 тогтоол батлан гаргасан байна.

Лүн сумын ИТХ-ын ээлжит бус 03 дугаар хуралдааныг 2021 оны 03 сарын 16-нд хуралдаж, хуралдаанаар:-

1. Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай

2. Хөрөнгө актлах тухай

3. Шилжих үлдэгдлийг тодотгон батлах тухай

4. Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд санал авах тухай /Би би жи покет ХХК /

5. Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд санал авах тухай /Хос цагаан зам ХХК /

6. Хог хаягдлын үйлчилгээний хураамж шинэчлэн тогтоох тухай

7. Спорт цогцолборын үйлчилгээний журам батлах, үнэ тариф тогтоох зэрэг 7 асуудал хэлэлцэж 7 тогтоол батлан гаргаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлэхээр 3 тогтоолыг зохих хууль, журмын дагуу материалыг бүрдүүлж хуулийн хугацаанд нь хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын төлөөлөгчдөд малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай суртгалтыг хуралдааны өмнө зохион байгуулснаас гадна сумын ИТХ-ын төлөөлөгчдийг АТГ-аас зохион байгуулсан цахим сургалтад хамруулсан байна.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд:

Аймгийн удирдах ажилтны нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг 03 дугаар сарын 01, 29-ний өдрүүдэд 2 удаа цахимаар зохион байгуулж, даалгавар өгч хэрэгжилтийг тооцон ажиллалаа.

Монгол хэлний зөв бичиг, найруулга зүйн сургалтыг 03 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн Пүрэв гараг бүрт “Хүмүүн цогцолбор сургууль”-ийн Монгол хэл, уран зохиолын багшаар заалгаж байна. Уг сургалтын хөтөлбөр дуусмагц Монгол бичгийн хичээл эхлэх юм.

Төрийн албан хаагчдын харилцаа, хандлагад эерэг өөрчлөлт бий болгох замаар иргэдийн сэтгэл ханамжит төрийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2021.03.09-2021.03.23-ны хооронд аймгийн Засаг даргын Тамгын газар, 27 сум, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа хэлтэс, агентлаг, байгууллагуудын хүрээнд “ХАРИЛЦАА, ХАНДЛАГА САЙЖРУУЛАХ АЯН” зарлан удирдамжийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтийг тооцов. Үүнд:

-Иргэд, төрийн албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч, түүний мөрөөр авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх,

-“Иргэдийн сэтгэл ханамжит төрийн үйлчилгээ бий болгох нь” сэдэвт илтгэлийн уралдаан зохион байгуулж, үйлчилгээнд нэвтрүүлэх,

-“Мэндэлье, хүндэлье, талархъя” арга хэмжээ зохион байгуулах,

-Албан хаагчдад эерэг харилцаа хандлага бий болгох сургалт зохион байгуулах.

Уг аянд 12 байгууллага, 12 сум нэгдсэн тайлан ирүүлсэн байна.

Аймгийн “Хөгжлийн төслийн баг” Соёлын яамны “Соёл, урлагийг дэмжих сан”-аас зарласан төслийн сонгон шалгаруулалтад оролцох үүргийг 27 сум, Боловсрол, соёл урлагийн газар, аймгийн музей, Монгол туургатан театр, нийтийн номд санд хүргүүлэн, холбогдох 3 мэргэжилтэнг арга зүйн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу 13 төсөлд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн, аймгийн Засаг дарга болон Засаг даргын орлогч бөгөөд “Хөгжлийн төслийн баг”-ийн даргын дэмжсэн 2 албан тоотоор Соёлын яамны Үйлдвэрлэл, инновацийн хэлтэст хүргүүлэв.

Мерит төсөлд “Хамтын ажиллагаа сайтай эерэг орчинг бүрдүүлэх нь” сургалт захиалан Канадын зөвлөх Will Gow-ийн удирдлаган дор синхрон орчуулгатайгаар эхний ээлжний 20 албан хаагч хамрагдлаа.

Аймгийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний төслийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлэн “Аймгийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”-г 39 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 3 дугаар 18-ны өдрийн 20 дугаар тогтоолоор батлуулав. Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн ээлжит бус хуралдаанаар 9 асуудал хэлэлцүүлж ажиллав.

Аймгийн хэмжээнд Коронавируст /Ковид-19/ цар тахалын батлагдсан тохиолдол 174 бүртгэгдэж, сүүлийн 14 хоногт батлагдсан тохиолдол эрс нэмэгдэж 8 суманд Нийслэл Улаанбаатар хот болон бусад эх үүсвэртэй халдварын шинэ голомтууд үүссэнтэй хоблогдуулан онцгой нөхцөлд чиг үүргээ хэрэгжүүлж буй ажилтан албан хаагчдын үүрэг хариуцлагыг сайжруулж, удирдлагаар шуурхай хангах, төрийн албан хаагчдад хэвлэл мэдээлэл, олон нийт, нийгмийн сүлжээний орчинд үнэн бодит, нэгдмэл байр сууринаас иргэдийг мэдээллээр хангахад анхаарч, халдварын голомттой (Нийслэл Улаанбаатар хот, бусад аймаг, орон нутаг) бүс нутагт хүндэтгэн үзэх (эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, буяны ажил) шалтгаанаас бусад тохиолдолд зорчихгүй байх, хяналт тавих, Засгийн газар, Улс, аймгийн Онцгой комиссын шийдвэрийг нэг мөр хэрэгжүүлэх талаар аймгийн Засаг даргын 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 01/487 дугаар албан бичгээр албан байгууллагын дарга, Сумын Засаг дарга нарт чиглэл өгч ажиллаа.

2021 оны 3 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар Монгол Улсын төрийн дээд одон медалиар шагнуулахаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн 49 иргэний тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, /Үүнээс ТАХ 24/ холбогдох яам, дээд шатны байгууллагад уламжлаад байна. Холбогдох яам, дээд шатны байгууллагаас дэмжсэн санал ирүүлсэн 95 иргэний материалыг /Үүнээс ТАХ 11/ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж ажиллаа.

Хүний нөөцийн бодлого зохицуулалтын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын хүний нөөцийн бүртгэлийг шинэчлэн нийт 16 төрлийн судалгааг мэдээллийг аймгийн



Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Хэлтэс, агентлаг, 27 сумаас нэгтэн гаргаж холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлж ажиллав.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академийн хамтран зохион байгуулсан Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт хэрэгжилт “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны зайн сургалтад аймгийн ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, ХШҮДАХ-ийн дарга, ТЗУХ-ийн Орон нутгийн бодлого зохицуулалт хариуцсан Ахлах мэргэжилтэн, ХОХБТХ-ийн Хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан Ахлах мэргэжилтэн, Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтнийг тус хамрууллаа.

Төрийн албаны зөвлөлийн төв аймаг дахь салбар зөвлөлийн чиглэлээр:

1. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Төв аймаг дахь салбар зөвлөл 2021 онд “Төрийн албаны шинэтгэлийг бэхжүүлэх” уриа дэвшүүлэн 01 дүгээр тогтоолоор үйл ажиллагааны төлөвлөгөөгөө баталсан. МУЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журам, аргачлалын дагуу төлөвлөгөөний хэрэгжилтэд 1 дүгээр улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 53.2%-ийн гүйцэтгэлтэй гарав.




2021 оны 1 дүгээр улирлын байдлаар салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд 11 тогтоол гаргалаа. Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 75.12%-тай байна.

Төрийн 130 байгууллагын ёс зүйн зөвлөлд 2019.01.01-2021.03.15-ны хооронд ирсэн өргөдөл гомдол, зөрчлийн мэдээ, түүний

шийдвэрлэлтийн талаарх судалгааг гарган дүн шинжилгээ хийлээ.

Ирсэн өргөдөл гомдол, түүний шийдвэрлэлт (оноор):



Зохион байгуулсан сургалт, хамрагдсан албан хаагчдын давхардсан тоо (оноор):

Он	Сургалтын тоо	Хамрагдсан ТАХ-ийн тоо
2019	293	4941
2020	248	4580
2021.03	83	2184

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу 205 иргэний нөөцийн бүртгэл, мэдээллийг шинэчлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

№	Нөөцийн бүрэлдэхүүн	Иргэний тоо
1	Ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэний нөөц /2019-2020/	191
2	Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаал эрхэлж байсан албан хаагчийн удирдах албан тушаалтны нөөц	2
3	Төрийн жинхэнэ албан тушаалаас түр чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц	8
4	Төрийн албаны тухай хуулийн 62.1.4-т заасан болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу цэргийн тэтгэвэр тогтоолгож /дээдофицер, офицер, ахлагч/ төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн иргэний нөөц	2
5	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжихээс өмнө нөөцөд байх заалтаар ажлаас чөлөөлөгдсөн	2
НИЙТ ДҮН		205

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 2 байгууллагад 160 иргэний нөөцийн мэдээлэл, 3 иргэн нөөцөд бүртгэлтэй лавлагаагаар үйлчиллээ.

Сул орон тоо нөхөх тусгай шалгалтад оролцогчдоос нөөцөд бүртгэлтэй 10 иргэн хамгийн өндөр оноотой тэнцэн нэр дэвшиж, ажлын байртай боллоо.

Сум, орон нутгийн боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэх, төрийн албаны сул орон тоог мэргэжлийн шаардлага хангасан орон нутгийн иргэдээс нөхөх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Их, дээд сургуульд суралцаж буй Төв аймгийн оюутан, залуусын судалгаа”-г 27 сумаас авч, нэгтгэх ажил хийгдэж байна.

Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд үүсч буй хүндрэл, бэрхшээл, мөн төрийн албаны ангилал, зэрэглэлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх шийдлийн талаар 23 санал боловсруулан ТАЗ-д хүргүүллээ.

Төрийн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн, албан тушаалтныг чадавхижуулах, харилцан бие биенээсээ туршлага судлах, мэдээлэл солилцох, нийгэмд чиглэсэн зөв хандлага тогтоох сайн дурын үйл ажиллагаа бүхий “Төв HR” клубыг 2021.03.18-ны өдөр байгуулан, анхны уулзалтаа цахим хэлбэрээр зохион байгуулж, 2021 оны ажлын төлөвлөгөөгөө баталлаа. Клубт 26 агентлагийн хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагч хамрагдсан байна.

Төв аймагт үүссэн коронавируст цар тахал, байгалийн гамшгийн нөхцөл байдлын улмаас орлогын тогтвортой эх үүсвэргүй суурин болон хөдөөгийн айл өрхүүд, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд эдийн засаг, нийгмийн болон сэтгэл зүйн олон хүндрэл бэрхшээл тулгарч байна. Иймд Төв аймаг дахь салбар зөвлөл, аймгийн ЗДТГ, “Төв HR” клубтэй хамтран гамшгийн нөхцөл байдлыг хохирол багатай даван туулахад ард иргэддээ дэмжлэг болох зорилгоор нийт төрийн байгууллага, албан хаагч нартаа хандан 4 арга хэмжээ бүхий уриалга гарган хүргүүллээ

Тайлант хугацаанд төрийн алба, төрийн байгууллага, албан хаагчтай холбоотой дараах судалгаа мэдээллийг шинэчлэн гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнд:

1. 8 агентлаг, 27 сумын ИТХ, ЗДТГ-ын бүтэц, 662 орон тоо, түр орлон гүйцэтгэгч, Ковидын хуультай холбоотой томилгоо хийсэн талаарх тоон мэдээлэл (2021.03.04)
2. Төрийн 130 байгууллагын ёс зүйн зөвлөлд 2019.01.01-2021.03.15-ны хооронд ирсэн өргөдөл гомдол, зөрчлийн мэдээ, түүний шийдвэрлэлтийн талаарх судалгаа (2021.03.22)

2021 оны 03 дугаар сарын байдлаар хариутай бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг танилцуулбал:

Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариута	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй	Шийдвэрлэлтийн
-------	------------	----------------	--------------	---------------	----------------

		й			хувь
Албан бичиг	56	44	41	3	93.2%
Өргөдөл, гомдол	6		5	1	83.3%

Салбар зөвлөлөөс 35 албан бичиг гадагш явуулснаас хариутай 26 бичиг байна. Үүнээс 11 нь хугацаандаа шийдвэрлэгдэж, 15 нь хугацаа болоогүй хүлээгдэж байна.

2. Сургалт, мэдээллийн чиглэлээр:

Төрийн албаны зөвлөлөөс цахим хэлбэрээр зохион байгуулсан 8 удаагийн сургалтад салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, холбогдох төрийн байгууллагын давхардсан тоогоор 200 гаруй албан хаагч хамрагдлаа.

ОУЭЭХӨ-ийг угтан 2021.03.04-нд зохион байгуулсан "Төрийн албан дахь эмэгтэйчүүдийн манлайлал" вебинарт аймаг, сумдын ахлах түшмэлийн албан тушаалд ажиллаж байгаа 37 эмэгтэй албан хаагч оролцсон.

Салбар зөвлөлөөс Канад улсын Мерит төсөлтэй хамтран төрийн байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчдыг "Ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ" сэдэвт цахим сургалтад хамруулах 2021.02.15-2021.03.24-ний хооронд ажлыг зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд 560 гаруй төрийн захиргааны албан хаагч ажиллаж байгаагийн 88.0% нь тус сургалтад идэвхтэй хамрагдаж, олон улсын гэрчилгээ авсан байна. (Уг сургалт нийт 600 албан хаагч бүртгүүлснээс 530 буюу 88.3% нь гэрчилгээ авсан)

Энэхүү сургалтад хамрагдсан албан хаагч нь жендэрийн талаарх мэдлэгээ бататган, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний боловсруулалтад жендэрийн мэдрэмжтэй хандаж, өөрийнхөө өрсөлдөх чадварыг ахиулах ач холбогдолтой юм.

3. Сонгон шалгаруулалтын чиглэлээр: Хойшилогдсон

Аймгийн нэгдсэн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба-төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн хүрээнд:

2021 оны 03 дугаар сард аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн дэмжих үйлчилгээний нийт **16** байгууллага **424** төрлийн үйлчилгээг **2786** иргэнд, өдөрт дунджаар **150-200** иргэнд хүргэж байна. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээ, арга хэмжээний мэдээллийг "Өлзий", ТBS, Төв, телевизүүдтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж иргэд олон нийтэд хүргэж байна. Мөн Аймгийн албан ёсны веб сайт болох www.tov.gov.mn, "Төв аймгийн хэвлэл мэдээллийн алба" нэртэй албан ёсны пейж хуудас, албаны мэдээллийн болон урсдаг самбар, ухаалаг дэлгэц зэрэг эх сурвалжаар иргэд, олон нийтэд түгээж байгаа бөгөөд энэ сард аймгийн веб сайтад **2**, "Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба" пэйж хуудсанд **141** мэдээ мэдээлэл тус тус нийтлэгдлээ. Харин 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг "Төв аймгийн цаг" нэвтрүүлгийн **2** дугаарыг бэлтгэн иргэд олон нийтэд хүргэсэн байна. Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **7** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжлан шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Одоогийн байдлаар хугацаа болоогүй **3** гомдол байна.

Мөн тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны E-mongolia цахим системийг нэвтрүүлж **16** байгууллагын **146** төрлийн лавлагаа мэдээллээр иргэдэд үйлчилж байгаа бөгөөд E-mongolia цахим системээр дамжуулан 03 сард аймгийн хэмжээнд **809** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ТҮНТөвийн оператор хэлбэрээр **121** лавлагаа үйлчилгээ авсан байна.

Мэргэжлийн хяналтын чиглэлээр:

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Монгол улсын Засгийн газар, УОК-ын шийдвэр, МХЕГ-ын даргын 2020 оны А/146 дугаар тушаал, Аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргын 2021 оны А/03, А/12, А/89, А/215

тоот захирамж, МХЕГ-ын 2021 оны 01/48 дугар удирдамж, Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/03, 06, 10, 11, 14, 25 тоот удирдамжуудын хүрээнд хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ.

1. Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 18 дугаар тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх түр журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэм сахиулах, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэх зорилгоор:

Халдвар хамгааллын дэглэм сахиулах, тусгай нөхцөл шаардлага хангуулах чиглэлээр Эрүүл ахуйн тухай, Гамшгаас хамгаалах тухай, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийг засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр нийт иргэн хуулийн этгээдийн бэлтгэл ажлын үед авах арга хэмжээ, зохион байгуулалтын арга хэмжээ, байгууллагуудын эрх үүрэг, сэжигтэй тохиолдол илэрвэл авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хариуцлагын арга хэмжээг тусгасан 1963 заалттай 151 зөвлөмжийг үйлдэж 27 сумын 135 аж ахуйн нэгж иргэдэд биечлэн тарааж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

БШУ-ны сайдын 2021 оны А/58 дугаар тушаал “Хүүхдийн цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах түр журам”, “Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах түр журам”-ын хэрэгжилтийг Зуунмод сумын 4 ерөнхий боловсролын сургууль, 7 сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хангуулж, зөвлөн тусалж ажилласан.

2. Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчооны хяналт, шалгалт:

Төв аймгийн хэмжээнд байнгын ажиллагаатай 3 шалган нэвтрүүлэх товчоо Лүн, Эрдэнэ, Сэргэлэн сумдад ажиллаж байна. Эдгээр байнгын ажиллагаатай 3 товчоодоор 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 10³⁰ цагийн байдлаар өссөн дүнгээр Зуунмод сумаас 9 тээврийн хэрэгсэл 20 иргэн гарсан, Зуунмод сум руу 29 тээврийн хэрэгсэл, 77 иргэн орсон, дамжин өнгөрсөн 62 тээврийн хэрэгсэл, 181 иргэний хөдөлгөөн, халдвар хамгааллын байдалд хяналт тавьж ажилласан. Буцаагдсан тээврийн хэрэгсэл 5 байна.

Голомтот бүс нутгаас зорчиж ирсэн иргэдийн ПиСиАр (PCR) шинжилгээ хийлгэсэн үр дүн, биеийн халуун хэмжилтэнд хяналт тавин, зорчигчдод зөвлөгөө өгч ажиллаж байна. Аймгийн хэмжээнд голомтын бүс нутаг болон тусгаарлан ажиглах байрнаас гарч орон нутагт ирсэн 340 иргэнийг (CLIX GPS SYSTEM) программын хяналтад бүртгэснээс 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 20 цагийн байдлаар 220 иргэн хяналтаас гарч, одоогийн байдлаар 120 иргэн хяналтад байна.

3. Тусгаарлан ажиглах байрны эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтэд Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/03 дугаар удирдамжийн хүрээнд аймгийн хэмжээнд тусгаарлах байраар ажиллах Төв аймгийн Халамж үйлчилгээний хэлтсийн харьяа Ахмадын амралт сувилал, Эрдэнэ сумын Ар Жанчивлан, Өвөр Жанчивлан рашаан сувилал, Сэргэлэн сумын Арга билэг сувиллын газруудын бэлэн байдлыг МХГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг төлөвлөгөөт бус хяналтыг хийж ундны уснаас дээж авч шинжилгээнд хамруулсан.

Ундны усны стандартын шаардлага хангаагүй 1 тусгаарлах байрны үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар түр зогсоосон.

Тус аймгийн хэмжээнд 03 дугаар сарын 06-ны өдрөөс хойш 16 тусгаарлан ажиглах байранд нийт 288 иргэнийг тусгаарлан ажигласнаас 12 иргэн коронавируст халдвар /Ковид-19/-аар өвчилсөн нь батлагдсан 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн цагийн байдлаар 5 байршилд 67 иргэнийг тусгаарлан ажиглаж байна. Үүнээс Заамар /кемп/ 11, Хөл

бөмбөгийн сургалтын төв 35, Наран жинс сувилал 10, Эрдэнэ сум (МСҮТ дотуур байр) 1, Мөнгөнморьт суманд / дотуур байр/ 10 иргэн тус тус тусгаарлалтад байна.

Мөн гэрийн ажиглалтад аймгийн хэмжээнд нийт **2664** иргэнийг хяналтад авснаас өнөөдрийн байдлаар **1237** иргэн хяналтад байна.

Голомтын бүс нутаг болон тусгаарлан ажиглах байрнаас гарч орон нутагт ирсэн 340 иргэнийг (CLIX GPS SYSTEM) программын хяналтад бүртгэснээс одоогийн байдлаар 120 иргэн хяналтад байна.

4. Нэг хаалга-Нэг шинжилгээ

“Нэг өрх-Нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд 2021 оны 03 дугаар сарын 09-10-ны өдөр Зуунмод сумын 6 багийн нийт 4541 хүнээс шинжилгээ авах үйл ажиллагаанд 22 улсын байцаагч хяналт тавьж ажилласан.

5. Дархлаажуулалт

2021 оны 03 сарын 26-ны өдөр АОК-ын дарга буюу аймгийн Засаг даргын А/213 дугаар захирамж болон Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар 2021.03.23-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар байгуулагдсан “Коронавирусын эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах” ажлын хэсэг 2021 оны 03 сарын 26-ны өдөр ХӨСҮТ-өөс коронавирусын эсрэг 0,5 мг-ийн фалконтой БНХАУ-ын Синофарм компанид үйлдвэрлэгдсэн “Синофарм Вероцелл” 1000 хүн тун вакцины зөөвөрлөлтөд Эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч хяналт тавин ажилласан.

2021 оны 03 сарын 27-28-ны өдрийн 09:00 цагаас 18:00 цаг хүртэл аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар / ГБХЗХГ/, Биеийн тамир спортын газарт/БТСГ/ нийт 2 цэгт аймгийн Вакцинжуулалтын ажлын хэсгийн 6, ӨЭМТ-ийн 21, АНЭ-ийн 14, МХГ-ын 3, ЭМГ-ын 7, ЦГ-ын 4, 2 цэгийн 7 үйлчилгээний албан хаагч **нийт 62** албан хаагч ажиллалаа.

2021 оны 03 сарын 27-ны өдөр ГБХЗХГ-ын дархлаажуулалтын 1-р цэгт нийт 13 байгууллагын 234 албан хаагч, БТСГ-ын 2-р цэгт ЭМГ, АНЭ, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 263 албан хаагч, нийт 497 албан хаагч вакцинжуулалтад хамрагдсан.

2021 оны 03 сарын 28-ны өдөр ГБХЗХГ-ын дархлаажуулалтын 1-р цэгт нийт 8 байгууллагын 127 албан хаагч, БТСГ-ын 2-р цэгт МХГ, ЭМГ, АНЭ, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 82 албан хаагч, нийт 209 албан хаагч вакцинжуулалтад хамрагдсан.

Зуунмод суманд зохион байгуулагдсан вакцинжуулалтад Эрүүл мэндийн салбарын 322, МХГ-ын 24, ОБГ-ын 59, ЦГ-ын 88, АОК-ын 23, бусад хариу арга хэмжээнд оролцогч болон стратегийн чухал ач холбогдол бүхий 13 байгууллагын 181, нийт 21 байгууллагын 706 хүнийг хамруулсан.

Мөн Эрдэнэ сумын онцгой комисс, Эрүүл мэндийн төвийн 60 албан хаагчийг 2021 оны 3-р сарын 28-ны өдрийн 16:00 цагаас 20:00 цаг хүртэл вакцинжуулалтад хамруулсан.

Төв аймагт нийт 1000 хүн тун вакцин хуваарилагдан ирснээс 706 вакциныг Зуунмод суманд, 60 вакциныг Эрдэнэ суманд албан хаагчдад хийж, 1 хүн тун вакцины хорогдол /тарилгын шприз соруулах үед татах хэсэг үйлдвэрлэлийн алдаатай байснаас үүдэн асгарсан./ гарсан бөгөөд үлдэгдэл 233 вакцин Эрүүл мэндийн газрын Вакцин хадгалах өрөөнд хадгалагдаж байна.

6. Төв аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/03, А/12, А/122, А215 тоот өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн арга хэмжээний тухай захирамжийн дагуу “Хүнсний худалдаа үйлдвэр, хадгалалт, түгээлтийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх”:

МХЕГ-ын 01/48 тоот удирдамжтай уялдуулан хяналт шалгалтын ажлыг давхардсан тоогоор 69 удаа хийж ургамал болон ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангуулах, Коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын байцаагчийн зөвлөмж 6 өгч, 12 нэр төрлийн 34ш, 5 кг нийт 147400 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг улсын байцаагчийн 8 заалттай 4 актаар хурааж, Сумын ЗДТГ-ын дэргэдэх орон тооны бус устгалын комисст шилжүүлэн ажилласан. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага 24 заалттай 3-ыг үйлдсэн биелэлт хугацаандаа ирсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/215, Зуунмод сумын Засаг даргын А/106 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулахаар Цагдаагийн газар, багийн Засаг дарга нартай хамтран согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй 55 хүнсний дэлгүүрийн 11307 ширхэг цагаан архи, 900 ширхэг дарс, 6987 ширхэг шар айраг, 62 ширхэг виски зэрэг согтууруулах ундааг битүүмжлэн, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллах талаар зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллалаа.

7. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламж барих газар олголт, зураг төсөл зохиох, ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийх удирдамжийн хүрээнд:

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламж барих газар олголт, зураг төсөл зохиох, ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийх 4 хүсэлт ирсэнээс зөвшөөрсөн 2, буцаасан 2 нийт 4 дүгнэлт гаргасан байна.

8. Төлөвлөгөөт ажил:

Байгаль орчны хяналтын чиглэлээр газрын даргын баталсан 19/07 дугаартай удирдамж, цагдаагийн газраас харьяаллын дагуу шилжин ирсэн гомдол мэдээллийн дагуу Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийхэд Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Юүдэгийн ам гэх газарт нэр бүхий 5 иргэн зөвшөөрөлгүй хуш модны самар түүж бэлтгэсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 1.500.000 төгрөгний шийтгэл, 4.113.000 төгрөгний нөхөн төлбөр оногдуулан улсын байцаагчийн 2021.03.16-ний өдрийн 19/04/-014/27 дугаартай улсын байцаагчийн актаар зохих зөвшөөрөлгүй түүж бэлтгэсэн 914 кг самрыг хураан авч Зуунмод сумын Засаг даргын даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлэн ажилласан.

Геологи, уул уурхайн хяналтаар:

Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/09 дугаартай удирдамжийн дагуу Төв аймгийн Заамар сумын нутагт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 15 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар 3 аж ахуйн нэгж Ашигт малтмалын тухай хууль болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заагдсан бүрдүүлбэл зохих баримт бичгийг бүрдүүлэн үйл ажиллагаа явуулж байна. Бусад аж ахуйн нэгжүүд нь уурхайн үйл ажиллагааны бэлтгэл, засварын ажил хийгдэж байна. 1 аж ахуйн нэгжийн илэрсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Төв аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 80 аж ахуйн нэгж, байгууллагад цахим хаяг болон бичгээр улсын байцаагчийн хамтарсан 19-05-016/72 дугаартай зөвлөмжийг хүргүүлсэн ажилласан.

9. Бусад

МХЕГ-ын 2021 оны 01/06 дугаар удирдамжийн дагуу 2021 онд тариалах үр тариа, төмс, хүнсний ногооны тарих үрийн чанарыг шинжилгээнд хамруулах ажил “Коронавируст халдварт /Ковид-19/ цар тахлын нөхцөл байдлаас хамаарч удаашралтай байна. Угтаалцайдам сумын ХААДС-ийн агуулахаас үр тарианы 9 дээж авч тарих үрийн чанарын, Зуунмод сумын 1 аж ахуй нэгж 3 иргэний 8 дээжинд нитрат, нитрит, ургамлын өвчин, хортонь шинжилгээнд хамруулсан шинжилгээний дүнгээр эерэг сорьц илрээгүй.

"Номын санг хүний хөгжил мэдээллийн цахим төв болгох нь" сэдэвт аймгийн Нийтийн номын сан, соёлын төв, ерөнхий боловсролын сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн номын санчдын онлайн сургалтад “Сум, сургуулийн номын санд хяналт шалгалт хийсэн байдал, илэрсэн зөрчлийг арилгах арга зам” сэдвээр илтгэл бэлтгэж оролцов. Сургалтад нийт номын санчдын 96.9 хувь хамрагдаж, сургалтад Соёлын яам, аймгийн ЗДТГ-ын НБХ, МХГ, Хүүхдийн төв номын сан, СУИС-ийн Соёлын сургуулийн холбогдох төлөөлөл сургалт хийлээ.

Сорилтын нэгдсэн лаборатори нь өнгөрсөн 1 сарын хугацаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 37 дээжийг хүлээн авч 186 үзүүлэлтээр хими, нян судлал, тарих үрийн чанарын болон хорио цээрийн шинжилгээг хийж, шинжилгээний хариуг хугацаанд нь гарган ажилласан.

Онцгой байдлын газрын хүрээнд:

№		Огноо	Мэдээ өгсөн хүний нэр, утасны дугаар	Мэдээний агуулга /Байршил/	Хүн хүч техник хэрэгсэл	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
		Цаг минут				
Зуунмод сум /Объектын галын бүртгэл/						
1		2021.01.16 01:56 цагт	Иргэн Цэрэндорж /70272973/	"Энхтайван" 6 дугаар багийн 13 дугаар гудамжны 33 тоотод пийнингийн яндан улаасаад гэр шатах гэж байна гэсэн мэдээлэл хүлээн.	ГТУА 24-р ангийн Салааны захирагч дэслэгч Б.Батзоригор ахлуусан 6 албан хаагч, 1 автомашинтай гарч ажиллсан.	Зөрчлийн дуудлага байсан.
2		2021.01.22 20:34 цагт	Иргэн С.Алтантуяа /94959360/	"Дэнж" 2 дугаар багийн 6 дугаар гудамжны 18 тоотод оршин суугч иргэн Д.Дашаагийн байшингийн дээвэр шатаж байна гэсэн мэдээлэл хүлээн авсан	ГТУА 24-р ангийн Салааны захирагч дэслэгч Б.Даваа-Эрдэнээр ахлуусан 6 албан хаагч, 1 автомашинтай гарч ажиллсан.	
3		2021.02.05 18:50 цагт	Иргэн Ж.Цэцэгдээ 99301227	Энхтайван 6-р багийн 12 гудамжны 3 тоот таамбар шатаж байна гэсэн дуудлага өгсөн	ГТУА 24-р ангийн салааны захирагч дэслэгч Б.Бямбанямаар ахлуулсан 5 албан хаагч 1 автомашинтай гарч ажиллсан.	Зөрчлийн дуудлага байсан.
4		2021.02.22 02:56 цагт	Иргэн Б.Цогзолсаа /91383807/	"Энхтайван" 6 дугаар багийн 11 дугаар гудамжны 35 тоотод 8*6 хэмжээтэй өвлийн байшингийн дээвэр хэсгээс утаа гараад байна	ГТУА 24-р ангийн салааны захирагч дэслэгч Б.Бямбанямаар ахлуулсан 5 албан хаагч 1 автомашинтай гарч	Зөрчлийн дуудлага байсан.

				гэсэн мэдээлэл хүлээн авсан.	ажилласан.	
5		2021.03.05 12:38	Иргэн Д.Оюунсүрэн /88036910/	"Зүүндэлгэр" 4-р багийн А15 дугаар гудамжны 3 тоотод оршин суугч иргэн Ш.Эрдэнэжаргалын эзэмшилийн "Акметг" загварын 52-98 ТӨВ улсын дугаартай автомашин шатаж байна гэсэн дуудлага хүлээн авсан.	ГТУА 24-р ангийн салааны захирагч дэслэгч Б.Бямбанямаар ахлуулсан 6 албан хаагч 1 автомашинтай гарч ажилласан.	Бүрэн утраасан.
Хөдөө орон нутгийн /Объектын галын бүртгэл/						
1		2021.01.04 16:25 цагт	Тус сумын ЗДТГ-ын дарга А.Пүрэвсүрэн /99990845/	Эрдэнэ сумын "Баянтуул 3-р багийн "Шивэртийн" гэдэг газарт /сумын Төвөөс хойд зүгт 80-км-т/ Иргэн Д.Ганхуягын 5-н ханатай гэр эд хогшилын хамт бүрэн шатсан мэдээлэл хүлээн авсан.	-	-
2		2021.01.10 17:00 цагт	Тус сумын ЭХАБүлгийн дарга д/ч Б.Мөнхбаяр /80107105/	Лүн сумын Төв 3-р баг Тээгийн 4 гудамжны 113 тоотод иргэн А.Дэлгэрдалайгийн 7*8 хэмжээтэй шавар байшингийн дээвэр хэсэг 16:30цагт шатаж байна гэсэн дуудлага хүлээн авсан.	Тус сумын ЭХАБүлгийн дарга д/ч Б.Мөнхбаяраар ахлуулсан 5-н алба хаагч 1 автомашин, орон нутгаас 7 хүн 2 автомашинтай ажилласан.	Галын бүрэн унтраасан.
3		2021.01.24 19:24 цагт	Мөнгөнморьт сум дахь ГТУА 75-р ангийн ШУОператор д/а Б.Гандирмаа /80106101/	Мөнгөнморьт сумын "Жаргалант" багийн "Их гудамж" гэдэг газарт /сумын төвөөс зүүн зүгт 35 км-т/ иргэн н.Баасан өвөлжөө шатаж байна гэсэн дуудлага хүлээн авсан.	Тус сум дахь ГТУА 75-р ангийн захирагч ахмад 3.Билгүүнээр ахлуулсан 4 алба хаагч 1 автомашинтай гарч ажилласан.	Галын бүрэн унтраасан.
4		2021.01.30 01:00цагт	Тус сумын ЭХАБүлгийн дарга д/ч Б.Мөнхбаяр /80107105/	Лүн сумын Төв 3-р баг Рашаантын 184 тоотод оршин суугч иргэн Ц.Цээнямбуугийн байшмнгийн дүнг амбаарын 12*3 хэмжээтэй дээвэр шатаж байна гэсэн дуудлага хүлээн авсан.	Тус сумын ЭХАБүлгийн дарга д/ч Б.Мөнхбаяраар ахлуулсан 3-н алба хаагч 2 автомашинтай ажилласан.	01:02 цагт очиход амбаарын дээвэр хэсэг шатаж байсныг бүрэн унтраасан.
5		2021.02.21 14:40 цагт	Тус сумын ЗДТГ-ын дарга Ж.Алтангэрэл /99201083/	Заамар сумын төв багийн сумын төвдөө 5-р хэсэг 3-р гудамжны 5 тоотод оршин суугч Г.Батжанцангийн 12*10 хэмжээтэй байшгийн эд хогшил мөн залгаа абмаар, грашын бүрэн шатсан гэсэн мэдээлэл хүлээн авсан.	Тус сумын ЗДТГ-ын дарга Ж.Алтангэрлээр ахлуулсан 100 иргэн 5 автомашинтай ажилласан.	
7		2021.03.03 13:53 цагт	иргэн н.Амаржаргал /88037398/	Төв аймгийн Аргалант сумын Аргалын уул 1 дүгээр багийн "Билүүтийн	Тус сумын Аргалын уул багийн 15 иргэн, 3 автомашинтай	14:03 цагт очиход иргэн

				худаг" гэдэг газарт /Аймгийн төвөөс баруун зүгт 148 км-т, сумын төвөөс баруун урд зүгт 17 км-т/ оршин суугч иргэн Ж.Содномдаржаагийн саравч шатаж байна гэсэн мэдээллийг хүлээн авсан	ажилласан	Ж.Содномд аржаагийн 30х4 хэмжээтэй саравч шатаж байсныг 15:07 цагт бүрэн унтраасан. 30х4 хэмжээтэй саравчнаас 18х4 хэмжээтэй саравч шатсан . Уг гал түймэрт бэртэж гэмтсэн хүн байхгүй.
6		2021.03.08 17:16 цагт	ГТУА 75-р ангийн ШУОператор д/а Б.Мандухай /80106101/	Мөнгөнморьт сумын Булаг багийн "Мөнх жаргалант"- ын 15 дугаар гудамжны 9 тоот / сумын төвдөө хойд зүгт 1 км-т/ 3.Ягаан гэдэг айлын 3*3 хэмжээтэй амбаар шатсан тухай дуудлага хүлээн авсан.	ГТУА 75-р ангийн захирагч ахлах дэслэгч 3.Билгүүнээр ахлуулсан 4 албан 1 автомашинтай гарч ажилласан.	Бүрэн унтраасан.
7		2021.03.10 20:05 цагт	Батсүмбэр сумын ГТУА ангийн ШУОператор д/а Ц.Эрдэнэбилэг /80107101/	Батсүмбэр сумын "Мандал" багийн "Үйлдвэрлэлийн 1 дүгээр гудамжны 5 тоотод иргэн Д.Ганбаярын эзэмшилийн 2 давхар дүнзэн байшин шатсан тухай дуудлага хүлээн авсан.	ГТУА аагийн салааны дэслэгч Б.Пүрэв-Очиороор ахлуулсан 4 алба хаагч 1 автомашинтай гарч ажилласан.	2 давхарын дээвэр хэсэг дээвэртэйг ээ бүрэн шатсан.
Гамшиг ослын бүртгэл						
1		2021.01.07 14:25 цагт	Ариунтуяа /88071038/	"Зуунмод" сумын Номт багийн Дуулиант 1 дүгээр уурын зуухны овоолсон нүүрс нурж иргэн Б.Баярбат 45 настай эрэгтэй дарагдсан тухай дуудлагыг хүлээн авсан.	ОБГ-ын ЭХАС-ын дарга а/д 3.Отгонзулаар ахлуулсан 4 алба хаагч 1 автомашинтай арч ажилласан.	11:27цагт очиход нүүрсэнд дарагдсан иргэн харагдахгүй байсан нурсан нүүрсний хүрз болон тармуур ашиглан 3метр дарагдсан иргэнийг эсэн мэнд гаргаж 103 түргэн тусламжийн эмч 3.Түвшинс айханд

						хүлээлгэн өгсөн.
2		2021.01.18 07:10цагт	Тус сумын ЗДТГ-ын дарга Б.Давагжамц /99172967/	Сүмбэр сумын"Жаргалант" багийн "Дуудан" гэдэг газарт / сумын төвөөс баруун хойд зүгт 18 км-т/ приус 11 загварын автомашин цасанд суусан тухай мэдээлэл хүлээн авсан.	Тус сумын ЗДТГ-ын дарга Б.Давагжамцаар ахлуулсан 2 иргэн 1 автомашинтай очиж ажилласан.	Цасанд суусан автомашин ыг гаргасан
3		2021.01.18 07:10 цагт	Иргэн Ж.Алтангэрэл /99179637/	Заамар сумын "Төмстэй" багийн "Өвөр наймган" гэдэг газарт /сумын төвөөс баруун зүгт 40 км-т/ иргэн Б.Биндэрьяа /10 настай эмэгтэй / 15 цагийн орчим малдаа яваад сураагүй алга болсон	Тус сумын Засаг дарга Л.Амгаланбаяраар ахлуулсан 27 иргэн, 5 автомашинтай эрлийн ажиллагаа эхлүүлсэн.	12:45 цагт гэрээс нь баруун хойд зүгт 5 км-т ""Өвөр наймган" гэдэг газраас олсон. Аав Б.Батцогтод хүлээлгэн өгсөн.
4		2021.01.29 19:25 цагт	Иргэн Ж.Дөлгөөн	Сэргэлэн сумын "Хайрхан" багийн "Авдарын уул" гэдэг газарт /сумын төвөөс баруун зүгт 50 км-т/ иргэн Т. Отгончулуун /54 настай эмэгтэй/ малчидтай гэрээ байгуулахаар яваад сураагүй алга болсон дуулага өгсөн.	Сумын хэсгийн төлөөлөгч дэслэгч Г.Бөхбаатараар ахлуулсан 5 хүн, 1 автомашинтай эрэн хайх ажиллагаа явуулсан.	Иргэн Г.Отгончулууныг айлд байхад нь олж ар гэрийн хүмүүс нь хүлээлгэж өгсөн.
5		2021.02.06 13:41 цагт	Цагдаагийн газрын жижүүр д/а Т.Тунгалагтуяа /70194750/	Баянцагаан сумын "Баян айраг" багийн "Хатадын дэрс" гэдэг газар /сумын төвөөс хойд зүгт 50 км-т/ Лүн сумын харъяат иргэн Э.Хатанбаатар /35 настай эрэгтэй/ худагт унаж нас барсан мэдээлэл хүлээн авсан.	Уг дуудлагын дагуу Цагдаагийн газраас ахлах мөрдөн байцаагч С.Эрдэнэбилэгээр ахлуулсан 6 алба хаагч 1 автомашинтай ОБГ-аас ЭХАС-ын усчин аврагч а/ч Т:Батжаргалтай гарсан.	Тус иргэн согтууруулах удаа хэрэглэж худагт унасан байсан. 1метр 70 см гүнээс гаргаж авсан.
6		2021.02.28 16:55 цагт	Мөнгөнморьт сум дахь ГТУА 75-р ангийн ШУОператор д/а Б.Мандухай /80106101/	Мөнгөнморьт сумын "Жаргалант" багийн /сумын төвөөс зүүн зүгт 40 км-т/ "Хархираа" гэдэг газарт самарт явж байсан иргэн Ц.Болд / 51 настай эрэгтэй / сураагүй алга болсон тухай дуудлага өгсөн.	Мөнгөнморьт сум дахь ГТУА 75-р ангийн захирагч ахмад З.Билгүүнээр ахлуулсан 5 алба хаагч 1 автомашинтай гарч эрэн хайх аврах ажиллагаа явуулсан.	Иргэн Ц.Болд айлд байсныг олж ар гэрт хүлээлгэж өгсөн.
3 дугаар сарын гамшиг ослын бүртгэл						
1		202.03.14 12:20 цагт	Лүн сумын ЭХАбүлгийн дарга д/ч Б.Мөнхбаяр /80107105/	Лүн сумын Өгөөмөр багийн "Чавганцын хөтөл" гэдэг газарт, аймгийн төвөөс баруун зүгт 195 км-т/ /сумын төвөөс	Төв аймгийн Онцгой байдлын газрын Лүн сум дахь Эрэн хайх аврах бүлгийн дарга дэслэгч	15:46 цагт гэрээс 5 км газраас эсэн мэнд олсон аав

				баруун хойд зүгт 20 км-т/ 2021.03.14-ны өдрийн 10:00 цагт иргэн Д.Зинаметр 16 настай эрэгтэй малдаа яваад сураггүй алга болсон тухай дуудлага хүлээн авсан.	Б.Мөнхбаяраар ахлуулсан 4 алба хаагч, 1 автомашин, Ар гэрээс 3 хүн, 1 автомашинтай нийт- 7 хүн, 2 автомашинтай гарч ажилласан.	Доржод хүлээлгэн өгсөн.
2		2021.03.14 13:30 цагт	Засаг даргын тамгийн газрын дарга Б.Давгажамц /99172967/	Сүмбэр сумын "Жаргалант" баг "Тутан" гэдэг газарт, /Аймгийн төвөөс баруун зүгт 221 км-т/ /сумын төвөөс баруун хойд зүгт 15 км-т/ 2021.03.14-ны өдрийн 11:00 цагт иргэн Т.Дашням 15 настай эрэгтэй малдаа яваад төөрсөн тухай дуудлага хүлээн авсан.	сумын Засаг даргын тамгийн газрын дарга Б.Давгажамцаар ахлуулсан 6 хүн, 1 автомашинтай, Ар гэрээс 4 хүн, 1 автомашинтай нийт- 10 хүн, 2 автомашинтай гарч ажилласан.	16:10 цагт Жаргалант" баг "Тутан" гэдэг газраас 5 км-т, эсэн мэнд олж ар гэрт хүлээлгэж өгсөн.
3		2021.03.14 15:21 цагт	Засаг даргын тамгын газрын дарга Б.Сарантуяа /96655605	Эрдэнэсант сумын "Угалзат" баг "Баян" гэдэг газарт, /Аймгийн төвөөс баруун зүгт 281 км-т/ /сумын төвөөс урд зүгт 20 км-т/ 2021.03.14-ны өдрийн 13:00 цагийн орчим иргэн Ц.Цэрэндорж 13 настай эрэгтэй малдаа яваад төөрсөн тухай дуудлага хүлээн авсан	сумын Засаг даргын Орлогч дарга Г.Баттайванаар ахлуулсан 7 хүн, 1 автомашинтай эрэн хайх аврах ажиллагааг 15:26 цагт зохион явуулсан.	22:59 цагт "Угалзат" баг "Баян" гэдэг газраас 4 км-т хойд зүгээс /эсэн мэнд олсон/ ар гэрт хүлээлгэж өгсөн.
4		2021.03.14 15:26 цагт	Засаг даргын тамгын газрын дарга Б.Сарантуяа /96655605	Эрдэнэсант сумын "Угалзат" баг "Шар хотгор" гэдэг газарт, /Аймгийн төвөөс баруун зүгт 306 км-т/ /сумын төвөөс урд зүгт 45 км-т/ 2021.03.14-ны өдрийн 11:00 цагийн орчим иргэн Ц.Цэцэгмаа 55 настай эмэгтэй малдаа яваад төөрсөн тухай дуудлага хүлээн авсан.	Засаг даргын тамгийн газрын ИТХурлын дарга Х.Чинзоригор ахлуулсан 5 хүн, 1 автомашинтай эрэн хайх аврах ажиллагааг 15:30 цагт зохион явуулсан.	22:55 цагт "Угалзат" баг "Шар хотгор" гэдэг газраас 10 км-т зүүн урд зүгээс /эсэн мэнд олсон/ ар гэрт хүлээлгэж өгсөн.
5		2021.03.14 15:40 цагт	иргэн П.Дарханбаат ар /97000023/	Лүн сумын "Өгөөмөр" баг "Баруун ам" гэдэг газарт, /Аймгийн төвөөс баруун зүгт 213 км-т/ /сумын төвөөс баруун урд зүгт 40 км-т/ 2021.03.14-ны өдрийн 10:00 цагийн орчим иргэн Л.Төгсбаяр 17 настай эрэгтэй, Л.Мөнгөтөгс 15 настай эрэгтэй нар гэрээсээ малдаа гараад төөрсөн тухай дуудлага хүлээн авсан.	Онцгой байдлын газрын Лүн сум дахь Эрэн хайх аврах бүлгийн дарга дэслэгч Б.Мөнхбаяраар ахлуулсан 4 алба хаагч, 1 автомашинтай 15:40 цагт эрэн хайх аврах ажиллагаа зохион явуулсан.	гэрээсээ урд зүгт 5 км-т газраас эсэн мэнд олсон. Аав Лхагвасүрэн д хүлээлгэн өгсөн.
6		2021.03.14 16:41 цагт	Засаг даргын тамгын газрын дарга Н.Батбаяр	Баян-Өнжүүл сумын "Улаан ухаа" багийн "Баян эрхтий" гэдэг газарт /сумын төвөөс зүүн урд	Тус сумын Засаг даргын тамгын газрын дарга Н.Батбаяраар	19:09 цагт гэрээсээ урд зүгт 10 км-т

			/88072989/	зүгт 30 км-т/ иргэн А.Мөнхтулга 8 настай эрэгтэй гэрээсээ гараад төөрсөн тухай дуудлага хүлээн авсан.	ахлуулсан. 3 хүн, 1автомашинтай гарч ажилласан.	төөрсөн байсныг олж ар гэрт хүлээгэн өгсөн.
7		2021.03.14 23:37 цагт	Иргэн Б.Батцэцэг /88285611/	Баян-Өнжүүл сумын "бараат" баг "Ухаа овоо" гэдэг газарт, /Аймгийн төвөөс баруун урд зүгт 191 км-т/ /сумын төвөөс зүүн урд зүгт 60 км-т/ 2021.03.14-ны өдрийн 12:00 цагаас 13:00 цагийн хооронд иргэн Д.Цэрэндорж 20 настай эрэгтэй гэрээс малдаа гараад төөрсөн тухай дуудлага хүлээн авсан.	сумын Засаг даргын тамгын газрын дарга Н.Батбаяраар ахлуулсан 4 хүн 1 автомашинтай 00:59 цагт эрэн хайх аврах ажиллагааг зохион явуулсан.	07:20 цагт Бараат багийн "Хөх дэл" гэдэг газраас 60 км-т хээр явж байсныг эсэн мэнд олж ар гэрт нь хүлээлгэж өгсөн.
8		2021.03.14 16:40	Иргэн Б.Батцэцэг /88285611/	Сэргэлэн сумын "Эрдэнэ-Уул" баг "Ханхай даваа" гэдэг газарт, /Аймгийн төвөөс баруун зүгт 30 км-т/ /сумын төвөөс урд зүгт 10 км-т/ 2021.03.14-ны өдрийн 12:00 цагийн орчим иргэн Б.Дамдинпүрэв 53 настай эрэгтэй гэрээс малдаа гараад төөрсөн тухай дуудлага хүлээн авсан.	Төв аймгийн онцгой бадлын газрын Эрэн хайх аврах салбарын дарга ахлах дэслэгч З.Отгозулаар ахлуулсан 5 хүн, 1 автомашинтай эрэн хайх аврах 02:38 цагт Эхнэр Б.Батцэцэг иргэн Б.Дамдинпүрэв Сэргэлэн "Авдар" багийн нутаг "Зараагийн энгэр" гэдэг газарт сумын төвөөс 30км-т иргэн М.Дөлгөөнамгалан гэдэг айлд ирлээ гэж 98994923 дугаарын утсаар мэдээ өгсөн байна ажиллагааг 23:03 цагт зохион явуулсан. Тус сумын Засаг даргын тамгын газрын дарга Н.Мөнхцэцэгээр ахлуулсан 5 хүн 1 автомашинтай 16:55 цагт эрэн хайх аврах ажиллагааг зохион явуулсан. Нийт- 10 хүн, 2 автомашинтай ажилласан.	02:38 цагт Эхнэр Б.Батцэцэг иргэн Б.Дамдинпүрэв Сэргэлэн "Авдар" багийн нутаг "Зараагийн энгэр" гэдэг газарт сумын төвөөс 30км-т иргэн М.Дөлгөөн амгалан гэдэг айлд ирлээ гэж 98994923 дугаарын утсаар мэдээ өгсөн байна
9		2021.03.22 08:10	Иргэн Г.Пүрэвбат /88853168/	Зуумод сумын Зүүндэлгэр багийн нутаг хар зам дагуу Г.Пүрэвбатын эзэмшлийн /ТӨВ 70-61/ улсын дугаартай "Верна" загварын судлын	Төв аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр ангийн 6 алба хаагч, 1	Зүүндэлгэр багаас аймгийн төв орох замд "Верна"

				автомашин шатаж байна гэсэн дуудлагыг 2020.03.22-ний өдрийн 08:10 цагт хүлээн авсан.	автомашинтай 3 километр замыг туулан 08:15 цагт голомтод хүрэлцэн очиж 250 литр ус зарцуулан 20 минут ажиллаж 08:35 цагт унтраасан. Уг гал түймэрт бэртэж гэмтсэн хүн байхгүй.	загварын автомашин ы хөдөлгүүр хэсэг шатсан.
10		2021.03.27 13:20	ЭХАБ дарга д/ч Б.Мөнхбаяр /80107105/	Лүн сумын "Цагаан уул" багийн "Их Айргийн шил" гэдэг газарт, /Аймгийн төвөөс баруун зүгт 181 км-т/ /сумын төвөөс зүүн хойд зүгт 16 км-т/ 2021.03.27-ны өдрийн 09:30 цагийн орчим иргэн З.Лхамсүрэн /32 настай, эмэгтэй/ гэрээсээ малдаа явна гэж гараад төөрсөн тухай дуудлагыг 2021.03.27-ны өдрийн 13:20 цагт хүлээн авсан.	Онцгой байдлын газрын Лүн сум дахь Эрэн хайх, аврах бүлгийн дарга дэслэгч Б.Мөнхбаяраар ахлуулсан 4 алба хаагч, 1 автомашинтай 13:20 цагт эрэн хайх аврах ажиллагаа зохион явуулж байна. 15:22 цагт гэрээс хойд зүгт 3 км-т Цагаан-Уул багийн "Их Айргийн шил" гэдэг газраас эсэн мэнд олж гэрт нь хүргэж өгсөн.	20-25 м/сек шороо болон цасаар шуурч байна. Уг иргэн малдаа явганаар явсан.
11		2021.03.27 12:40	ЭХАБ дарга д/ч Б.Мөнхбаяр /80107105/	Лүн сумын "Цагаан уул" багийн "Цагаан хөтөл" гэдэг газарт, /Аймгийн төвөөс баруун зүгт 201 км-т/ /сумын төвөөс урд зүгт 26 км-т/ 2021.03.27-ны өдрийн 09:00 цагийн орчим иргэн Б.Доржпүрэв /54 настай, эрэгтэй/ гэрээсээ малдаа явна гэж гараад төөрсөн тухай дуудлагыг 2021.03.27-ны өдрийн 12:40 цагт хүлээн авсан	Онцгой байдлын газрын Лүн сум дахь Эрэн хайх, аврах бүлгийн дарга дэслэгч Б.Мөнхбаяраар ахлуулсан 4 алба хаагч, 1 автомашинтай 12:40 цагт эрэн хайх аврах ажиллагаа зохион явуулж гэрээс урд зүгт 8 км-т Цагаан-Уул багийн "Цагаан хөтөл" гэдэг газраас эсэн мэнд олж гэрт нь хүргэж өгсөн.	20-25 м/сек шороо болон цасаар шуурч байна. Уг иргэн мотоцикльтой малдаа яваад түлшгүй болоод мотоциклоо үлдээгээд явган явсан.
12		2021.03.03 13:53	иргэн н.Амаржаргал /88037398/	Аргалант сумын Аргалын уул 1 дүгээр багийн "Билүүтийн худаг" гэдэг газарт /Аймгийн төвөөс баруун зүгт 148 км-т, сумын төвөөс баруун урд зүгт 17 км-т/ оршин суугч иргэн Ж.Содномдаржаагийн саравч шатаж байна гэсэн мэдээллийг 2021.03.03-ны өдрийн 13:53 цагт хүлээн авсан.	Аргалын уул багийн 15 иргэн, 3 автомашинтай 14:03 цагт очиход иргэн Ж.Содномдаржаагийн 30х4 хэмжээтэй саравч шатаж байсныг 15:07 цагт бүрэн унтраасан. 30х4 хэмжээтэй саравчнаас 18х4 хэмжээтэй саравч	

					шатсан . Уг гал түймэрт бэртэж гэмтсэн хүн байхгүй.	
13		2021.03.10 20:05	иргэн н.Нармандах /86005757/	Батсүмбэр сумын Мандал 1 дүгээр багийн Үйлдвэрлэлийн 1 дүгээр гудамжны 5 тоотод /сумын төвдөө/ оршин суугч иргэн Д.Ганбаярын 10x18 хэмжээтэй 2 давхар дүнзэн байшин шатаж байна гэсэн дуудлагыг 2021.03.10-ны өдрийн 20:05 цагт хүлээн авсан.	Онцгой байдлын газрын Батсүмбэр сум дахь Гал түймэр унтраах, аврах ангийн 4 алба хаагч, 1 автомашинтай, Засаг даргын Тамгын газраас 5 ажилтан, сум орон нутгаас 10 иргэн, 2 автомашинтай. Нийт 19 хүн, 3 автомашинтай ажилласан. 20:07 цагт очиход иргэн Д.Ганбаярын 10x18 хэмжээтэй байшингийн 2 давхрын хэсэг дээвэртэйгээ бүхэлдээ шатаж байсан. Байшин нь дотор гадаргүй модоор баригдсан байсан учир шатлага хурдан явагдаж гал түймрийг унтраахад хүндрэлтэй байсан учир байшин бүрэн шатсан. Уг гал түймэрт бэртэж гэмтсэн хүн байхгүй	Нэг давхарт байсан тавилга, эд хогшлыг /хөргөгч, буйдан, угаалгын машин, шүүгээ/ гал түймэрт өртөхөөс авран хамгаалсан .
14		2021.03.23 22:56		Говьсүмбэр аймгийн Баянтал сумын /сумын төвөөс хойд зүгт 22 км-т/ 2021.03.23-ны өдрийн 22:47:55 цагт 5.43 магнитутын хүчтэй газар хөдлөлт болсон тухай мэдээллийг 2021.03.23-ны өдрийн 22:56 цагт хүлээн авсан.	Газар хөдлөлтийн чичирхийлэлтийн мэдээг Төв аймгийн 27 сумын Тамгын дарга нартай холбогдоход Алтанбулаг, Аргалант, Архуст, Батсүмбэр, Баян, Баянжаргалан, Баянцагаан,Баянцог т, Баянчандмань, Жаргалант, Сүмбэр, Угтаалцайдам, Цээл, Борнуур, Эрдэнэсант, Өндөрширээт, Сэргэлэн сумдын засаг даргын Тамгын газрын дарга нар бага	Бусад сумдын Тамгын газрын дарга нартай холбогдохо д мэдрэгдсэн юм байхгүй гэсэн мэдээг өгсөн.

					зэргийн чичирхийлэл мэдрэгдсэн ямар нэгэн хохирол учраагүй гэж мэдэгдсэн.	
--	--	--	--	--	--	--

Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

Удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 43 шийдвэр, Онцгой нөхцөл байдалтай холбогдуулан гамшгийн үед ажиллах захирамж, албан даалгавар гэрээний 3 төслийн хууль зүйн үндэслэлийг хянан зөвлөмж өгч, хууль, эрх зүйн асуудлаар нийт 68 хүнд эрх зүйн туслалцаа үзүүлж, дотоод удирдлагын системээр дамжуулан шинэ хууль тогтоомжийн 6 төрлийн мэдээллийг байршуулан төрийн албан хаагчдыг хууль, эрх зүйн мэдээ мэдээллээр хангалаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар 18-ны өдрийн 03 дугаар хуралдаанаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019-2020 оны арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хэлэлцүүлж 96.87 хувьтай буюу “Үр дүнд хүрсэн” гэж дүгнүүлээ.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Шүүхийн шинжилгээний албанд криминалистикийн бичиг техникийн шинжилгээ хийх микроскоп авахад 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Аймаг, сум, багийн нийт 108 эрх бүхий албан тушаалтны 110 тамга, тэмдэгт хяналтын дугаар дахин авах асуудлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүсэлт уламжиллаа.

Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын даргад нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэх эрхийн зөвшөөрөл авахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд холбогдох баримт бичгийг хүргүүллээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах орон тооны байнгын Ажлын хэсэг хурлаар Төв аймгийн хэмжээнд үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2020 онд хийж, хэрэгжүүлсэн ажлын тайланг хэлэлцэн “Үндэсний аюулгүй байдлыг хангах 2021 оны нэгдсэн төлөвлөгөө”-г 3 зорилт 18 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр баталж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлж, чиглэл, санал авч ажиллалаа.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээх асуудлаар Эрдэнэ сумын иргэнээс ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийн бүрдлийг хангуулан Гадаадын иргэн харьяатын газарт санал уламжиллаа.

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран Зууны мэдээ сонин 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 03 дугаар сарын дугаарыг бэлтгэн радио телевизээр дамжуулан олон нийтэд сурталчиллаа.

Хүний эрхийн үндэсний комиссоос ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр цахим хурал, сургалт зохион байгууллаа.

Шүүхээр шийтгэгдсэн аймаг сумдын төрийн албан хаагчдаас бусдад хохирол учруулсан талаарх 2020 оны судалгааг аймгийн Шүүхээс авч дүгнэн сум, байгууллагуудад чиглэл өглөө.

Эрх бүхий албан тушаалтнаас батлан гаргасан, хүчин төгөлдөр байгаа Захиргааны хэм хэмжээний актын жагсаалтыг нэгтгэн гаргаж холбогдох чиглэлийг сумдын ИТХ, Засаг дарга нарт өгч ажиллалаа.

Архивын тасгийн чиглэлээр:

Энэ сард 121 иргэний хүсэлтийг цахимаар хүлээн авч 372 хуулбар хувь, 50 лавлагаа, 155 хөмрөгийн 487 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлэн ажиллав.

2 хөмрөгийн 49 хадгаламжийн нэгжийн 2981 хуудас баримтын 11742 хүний нэр, 2456 заалтын тоо, 2456 тушаалын тоог мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, 2 хөмрөгийн 49 хадгаламжийн нэгжийн 2981 хуудас баримт скайнердаж, 2 хөмрөгийн 49 хадгаламжийн нэгжийн 2456 заалтыг PDF.JPEG хэлбэрт хувиргаж, 2456 заалтын 2981 хуудас баримтыг цахим санд оруулж, эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг хийлээ.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 58508 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 10574, газар өмчлөх эрхийн 47934 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 26328.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 110 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 74 нэмэлт өөрчлөлт, шинээр 36 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 0, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 10 бүртгэл хийгдэж, бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 10 лавлагааг өгч, орон нутгийн төсөвт 4.4 сая төгрөгийг орууллаа.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлээр:

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 134 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдаж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 105 хэргээр буюу 44.3 хувиар буурсан. Гэмт хэргийн илрүүлэлт 34.6 хувьтай, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 хувиар өссөн.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Аймгийн зарим сумдад коронавируст халдварын цар тахлын тохиолдол гарсантай холбогдуулан Монгол улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Түр журам”, Улсын онцгой комиссын хурлын шийдвэр, аймгийн Засаг даргын А/215 тоот захирамжийн хэрэгжилтийг хангуулж Цагдаагийн газраас 185 албан хаагч, 27 сумын 85 хяналтын цэг, байнгын ажиллагаатай 9 постод 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 67 жолоочийг илрүүлж, 61 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасч, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 6 иргэнийг эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж, замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 1096 жолоочийг 56.4 сая төгрөгийн торгууль оногдуулан үүнээс 26 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатууллаа.

Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны чиглэлээр:

Энэ сард Криминалистикийн шинжилгээ-60, нийт хийсэн магадлан шинжилгээ-22, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-167, гарын хээний санг баяжуулсан-87, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 151 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
03 дугаар сар	245	80	6	319	64	255	20.1%
	4622247.6	681642.0	449441.9	4854447.7	402832.5	4451615.2	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд:

1. Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр:

1.1 Хөрөнгө оруулалт: Аймгийн хэмжээнд 2021 онд 56941,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэхээр төлөвлөгдлөө. Үүнд:

- Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 42351.9 сая төгрөгийн санхүүжилтээр 37 төсөл, арга хэмжээ тусгагдсанаас 2020 онд хэрэгжиж эхэлсэн 20 төсөл арга хэмжээ, эрх шилжиж ирсэн 12 төсөл, арга хэмжээ, эрх шилжиж ирээгүй 5 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 2 ажлын худалдан авах ажиллагааг зарлахаар үнэлгээний хороог байгуулж тендерийн баримт бичгийг боловсруулж байна.
- Орон нутгийн хөгжлийн сангаар 6357.8 сая төгрөгийн 43 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 23 төсөл, арга хэмжээ Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 12 төсөл арга хэмжээ харьцуулалтын аргаар нийт 35 төсөл арга хэмжээ тендер зарлахаар төлөвлөсөн. Үүнээс 17 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлаж 3 төсөл арга хэмжээнд гүйцэтгэгч шалгарсан байна.
- Аймгийн төсвийн шилжих үлдэгдлээр 3500.0 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 6 төсөл, арга хэмжээ Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 2 төсөл арга хэмжээ харьцуулалтын

аргаар нийт 8 төсөл арга хэмжээ тендер зарлахаар төлөвлөсөн. Үүнээс 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлаж 1 төсөл арга хэмжээнд гүйцэтгэгч шалгарсан байна.

- Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 682.0 сая төгрөгийн 13 арга хэмжээ хэрэгжихээс 4 төсөл, арга хэмжээ Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 2 төсөл арга хэмжээ харьцуулалтын аргаар нийт 6 төсөл арга хэмжээ тендер зарлахаар төлөвлөсөн. Үүнээс 5 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлаад байна.
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 752.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 20 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 4 төсөл, арга хэмжээ Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 6 төсөл арга хэмжээ харьцуулалтын аргаар, 2 төсөл арга хэмжээ зөвлөх сонгох бага үнийн аргаар нийт 12 төсөл арга хэмжээ тендер зарлахаар төлөвлөсөн. Үүнээс 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлаад байна.

Мөн 27 суманд 3296.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тус тусгагдлаа.

1.2. Худалдан авах ажиллагааны талаар зохион явуулсан ажил: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/607 дугаар захирамжаар батлуулж төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн цахим тендер шалгаруулалтын www.tender.gov.mn системээр батлуулж тендер шалгаруулалт зохион байгуулах эрхийг авсан. Батлагдсан төлөвлөгөөг нийтэд ил тод болгох ажлын хүрээнд Монголын Үнэн сонины 2021 оны 01 дүгээр сарын 11-ны №006 дугаарт, www.shilendans.gov.mn, www.tov.gov.mn, www.khural.mn сайтуудад байршуулан ажиллалаа.

2. Барилга, хот байгуулалтын чиглэлээр:

2.1.Барилга захиалагч, хяналтын чиглэлээр: Баян, Баянцагаан сумдын сургуулийн гал тогооны барилгын их засварын ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан. Баян сумын сургуулийн гал тогооны засварын ажил дууссан. Зуунмод сумын “Хүмүүн цогцолбор” “А” сургуулийн гал тогооны их засварын ажилд 6 удаагийн хяналт хийж гүйцэтгэгдсэн. Ашиглалтад оруулах улсын комисс ажилласан.

2.2. Ерөнхий архитекторын үйл ажиллагааны хүрээнд: Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 4 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан батлаж, Эрдэнэ сумын 15 ортой 2 давхар ЭМТөвийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар аж ахуйн нэгжид олголоо. Зураг төслийн даалгавар боловсруулах хүрээнд 2021 онд 7 зураг төслийн даалгаврыг боловсруулснаас 3-р сард 5 зураг төсөл боловсруулах даалгавар боловсруулсан байна.

2.3. Хот байгуулалтын кадастрын чиглэлээр: Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт 2019-2020 онд ашиглалтад оруулсан орон сууцны судалгааг нэгтгэн 2021.03.04-ний өдрийн тоот албан бичгээр, аймгийн хэмээнд гэр хороолол, амины орон сууцнаас бусад барилга байгууламжийн судалгааг гарган нэгтгэж 2021.03.15-ны өдөр цахимаар, "150 Мянган Айл-Орон сууц" үндэсний хөтөлбөр (2019-2023) ажлын хүрээнд орон сууц барихад инженерийн дэд бүтцийн ажилд шаардагдах төсөв, хөрөнгийн мэдээллийг Барилга хот байгуулалтын яаманд 2021 оны 03 сарын 26-ны өдөр цахимаар тус тус хүргүүлж ажиллалаа.

3. Газрын харилцааны чиглэлээр:

3.1. Суурь судалгаа газрын мониторингийн ажлын хүрээнд: 2021 оын 3 дугаар сарын 6-21-ны хооронд Сэргэлэн, Алтанбулаг сумын зарим нутаг дэвсгэрийг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газрын зориулалтаар Барилга, хот байгуулалтын яамны улсын тусгай хэрэгцээнд авах газрын нөлөөлөлд өртөж буй буюу тусгай хэрэгцээнд авах газартай давхцал бүхий иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргалаа. Уг судалгааны хүрээнд Сэргэлэн сумын газар эзэмшигч 1566 иргэн, хуулийн этгээд, Алтанбулаг сумын өмчлөгч 987, эзэмшигч 108 иргэн, хуулийн этгээдийн газар олголтын байдал, газар ашиглалтын өнөөгийн байдалд газар дээгүүр нь хэмжилт зураглал хийж ажиллалаа.

3.2.Газрын төлбөр: Эрх шилжилт хөдөлгөөн, 2018-2020 оны газрын төлбөрийн төлөлтийн судалгааг нарийвчлан гаргаж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлээ. 2021 оны 3 дугаар сард газрын төлбөрийн орлого 367.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 101.5 сая төгрөгийг төвлөрүүлж 27.6%-ийн гүйцэтгэлтэй байна. Өссөн дүнгээр 291.2 сая төвлөрч 27.7%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: 41.7 сая төгрөг дутуу төлөлтөөс төвлөрсөн байна. Жаргалант, Эрдэнэсант сумын газар эзэмших эрхийн дуудлага худалдаа 2021.03.26 -ны өдөр зохион байгуулагдаж байна. Баяндэлгэр суманд газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг зохион байгуулах зарыг “Газрын биржийн цахим систем” болон Байгууллагын хаягуудаар нээлттэй сурталчилсан.

3.3. Газрын кадастрын чиглэлээр: Богдхан уулын дархан цаазат газрын хилийн заагт орсон болон хилийн зааг дамнасан газруудын судалгааг хүснэгтийн дагуу гаргаж shp.file-ыг бэлтгэн газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүллээ.

Горхи-тэрэлжийн байгалийн цогцолборт газраас ирүүлсэн бичгийн дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргаас байгалийн цогцолборт газрын нутаг дэвсгэрт олголт хийгдсэн судалгааг гарган shp.file-ийг бэлтгэн Горхи-тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд хүргүүллээ.

Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу хаягийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлын хүрээнд 27 сумын багийн төв цэгийг тэмдэглэх ажлыг зохион байгууллаа.

ГХБХБГазрын 2021.01.15-ны а/02 дугаар тушаалаар хаягийн мэдээллийн систем ашиглан зам, гудамж, талбай нэгж талбар, үл хөдлөх хөрөнгөд хаяг, нэр, дугаар олгох засварлах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн удирдамжийн дагуу хариуцсан сумдынхаа хаягжуулалтын ажлыг эрчимжүүлж, 27 сумын хэмжээнд хаягжуулалтын ажил 80%-тай байна.

4. Орон нутгийн өмчийн чиглэлээр:

4.1. Өмчийн хүрээнд: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын дагуу Хуучин дулааны станцын барилга, түүнийг тоног төхөөрөмжийн 2 дахь дуудлага худалдааны зарыг аймгийн TBS, Төв телевиз, Монголын үнэн, зар мэдээ сонинд мэдээллийг байршуулж, сурталчилан түгээж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын дагуу 10 автомашины дуудлага худалдааг зохион байгуулж, 60 гаруй оролцогч оролцож 9 автомашин худалдагдаж, 1 машинд оролцогчгүй байв. Аймгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд 50,0 сая төгрөгийг төвлөрүүллээ.

“Хүлэмжийн парк”-ийн үйл ажиллагааг иргэн Т.Баярхүүтэй харилцан тохиролцсноор тодорхой хугацаанд эзэмшүүлэн Гидропоникийн тариалалтаар олон навчит ургамлыг тарих, хүүхэд, залуучууд, иргэдэд экологийн боловсрол олгох” сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах 3 талт гэрээг байгуулж, тус байгууллага хаврын тариалалтын бэлтгэл ажил хийгдэж байна.

4.2. Түрээсийн орон сууцны хүрээнд: МУЗГ-ын 2020.06.12 ны өдрийн 216 тоот тогтоолоор 2019 оны 138 дугаар тогтоолын “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ын 2.2.2 дахь заалтыг өөрчлөн найруулсантай холбогдуулан аймгийн “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу сонсох ажиллагаа зохион байгуулахаар tov.gov.mn, ОНӨГ-ын вэйт сайтад байршуулж, сумдад онлайнаар санал авах үйл ажиллагаа явагдаж байна.

Аймгийн “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд ны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ыг хэрэгжүүлж, нийт 25 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулж, 2021 оны 03 сарын 15-ны байдлаар 25 айлын түрээсийн төлбөр 8,865,245 төгрөгийг түрээсийн орон сууцны санд төвлөрүүллээ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Орон сууц” хөтөлбөрийн хүрээнд 80 айлын түрээслээд өмчлөх орон сууцыг барих тооцоо судалгааг гаргаж, аймгийн төсөвт тусгагдсан 800,0 сая төгрөгийг 80 айлын орон сууцны барилгын нийт санхүүжилтийн 30% -ийн эх үүсвэр санхүүжүүлж, үлдэгдэл 70% -ийг Төрийн банкын санхүүжүүлэлтээр баригдахаар төлөвлөн хэлэлцээрийн шатанд явагдаж байна.

5. Хөдөө аж ахуйн чиглэлээр:.....

5.1. Мал аж ахуйн хүрээнд: Мал аж ахуйн салбарын хаваржилт, төл хүлээн авах, хаврын тариалалтын ажилд болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх бэлтгэлийг хангуулах тухай аймгийн Засаг даргын 2021 оны 02 тоот албан даалгаврыг гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд төллөх насны хээлтэгчийн 7.0% буюу 159920 толгой хээлтэгч мал төллөж, 160713 толгой төл гарсаны 158790 толгой төл бойжиж, 1923 толгой төл мал хорогдоод байна. Мал аж ахуйн хаваржилт, төл хүлээн авах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын шийдвэрээр аюулгүйн нөөцийн өвсийг 30%-иар хямдруулан, 260 тн өвс, 76.0 тн тэжээлийг үйлдвэрийн үнээр сумдад хуваарилан олгож байна.

ХХААХҮЯам, Азийн хөгжлийн банкны хамтын ажиллагааны хүрээнд 26 сумын 1500 малчин өрхөд хүнсний багцын тусламжийг хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

НҮБ-ХХААБ-тай хамтран “Онцгой байдлын үед малд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах олон улсын заавар стандарт”(LEGS)-ыг танилцуулах, “RIMA - Даван туулах чадварын индексээр хэмжиж, дүн шинжилгээ хийх арга”-аар эрсдэлийг даван туулах чадварт малчин өрхийн нийгмийн үзүүлэлт хэрхэн нөлөөлж буй талаар, ХХААХҮЯ, ХААИС-тай хамтран сүргийн эргэлтийн тооцоо бодох аргачлал зэрэг 3 удаагийн

сургалтад 27 сумын багийн Засаг дарга, халамжийн мэргэжилтэн, хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн нийт 141 хүнийг хамруулж, зохион байгууллаа.

5.2. Мал эмнэлгийн үйлчилгээний хүрээнд: Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1915.6 мян.мал хамруулахаар төлөвлөж эм биобэлдмэлийн татан авалт 25.8 хувьтай, батлагдсан хуваарийн дагуу сумдад вакцины олголт 7 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 6777.0 мянган толгой малыг шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулах төлөвлөгөөг батлуулж, төлөвлөлтийг сумдын “Мал эмнэлгийн нэгдсэн систем”-д бүртгэх ажил 50 хувьтай байна. 3-р сарын 25-ны байдлаар 39253 мал хорогдсоноос 8847 мал, амьтны сэг зэмийг устгалд оруулан 25.2 мян/м2 талбайд ариутгал халваргүйтгэл хийсэн.

МХГ, ЭМГ хамтран аймаг сумдад ковид-19 бүртгэгдсэнтэй холбогдуулан нийтийн эзэмшлийн талбай, албан байгууллагын 115.2 мян/м2 талбайд халдваргүйтгэл хийлээ.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг нь 4 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа 189 тээврийн хэрэгсэл, тэмээ 21, адуу 230, үхэр 88, хонь 746, ямаа 36 толгой мал, мах, махан бүтээгдэхүүн 567.2 тн, арьс шир 22426 ширхэг, ноос 3 тн, ноолуур дайвар-7.35 тн, цагаан идээ-628 кг бүтээгдэхүүний эрүүл ахуй, мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийж 810 м2 талбайд халдваргүйтгэл хийсэн байна.

Мал эмнэлгийн ерөнхий газраас зохион байгуулсан “Мал эмнэлгийн салбарын бодлогын төлөвлөлт”, “Мал эмнэлгийн гэрчилгээ, түүнд тавигдах шаардлагын талаар цахим” сургалтад мал, амьтны эрүүл мэндийн албаны мэргэжилтэн, мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүд нийт 112 албан хаагчид хамрагдлаа.

5.3. Газар тариалангийн хүрээнд: 2021 онд нийт 122701,4 га /үр тариа 69467 га, улаанбуудай 63450 га, малын тэжээл 30250 га, тосны ургамал 10505, төмс 10000 га, хүнсний ногоо 1524 га, жимс 955.4 га/ талбайд тариалж хийж, үр тариа 86659 тн, улаанбуудай 79313 тн, малын тэжээл 84700 тн, тосны ургамал 6303 тн, төмс 130052 тн, хүнсний ногоо 19059 тн, жимс 1250 тн ургац хураан авахаар төлөвлөгөөтэй.

Хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд дутагдах үр, техник, шатахууны захиалгыг авч ХХААХҮЯаманд хүргүүлж, нөөцөлсөн үрийг шинжилгээнд хамруулах ажлууд хийгдэж байна. Одоогийн байдлаар 4 сумын 9 аж ахуйн нэгж талбайн чийг хаах ажил эхэлсэн.

2020 оны ургацаас 7676 тн үрийг нөөцөлж, 2021 онд нийт 14 сумын 281 иргэн, аж ахуйн нэгж 80832 га талбайд улаанбуудай тариалах захиалга өгсөн. Дутагдаж байгаа 8116 тн үрийн захиалга авч ХХААХҮЯ-д хүргүүллээ.

Таримал тэжээлийн дутагдаж байгаа 5080 тн үрийг аймгийн хэмжээнд нэгдсэн зохион байгуулалттайгаар ОХУ-аас татан нийлүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Эх орны элит сортын үрийг тариалж жил бүр аймагтаа үр үйлдвэрлэх, аймгийн шинэ бүтээл оновчтой саналыг дэмжих дэлгэрүүлэх асуудлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 170.0 сая төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүллээ.

ОХУ-аас нийлүүлэгдэж буй ХАА-н техник тоног төхөөрөмжийн захиалгийг авч нийт 181 иргэн, аж ахуйн нэгжийн 514 техник тоног төхөөрөмжийн захиалгыг хүргүүллээ.

АХБ-ны санхүүжилтээр Батсүмбэр суманд хэрэгжиж буй услалтын системийг сэргээн засварлах төслийн багийн цахим уулзалтыг хийж газар, услалтын системийн эзэмшил, засварын ажил хийхтэй холбогдуулан 2021 онд тариалах таримлыг сонгох зэрэг ажлууд хийгдлээ.

COVID-19-ийн хавдараас урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдах Улаанбаатарт байгаа 184, орон нутгийн 761 тариаланчдын судалгааг гарган, 03 сарын 27-нд Улаанбаатарт байгаа тариаланчдыг вакцинд хамрууллаа.

Тариаланчдад олгох 3% -ийн хөнгөлөлтэй зээлийн судалгааг нарийвчлан гаргаж, 3788 иргэн, ААН судалгааг авч, холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

5.4. Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд: Аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийг тогтвортой байлгах зорилгоор “Хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээ, хангалт, нөөцийн судалгаа”-г сум тус бүрээр гарган, 7 хоногийн Даваа, Пүрэв гараг бүр ХХААХҮЯ, аймгийн онцгой комиссыг мэдээллээр хангаж байна. 3 сарын 29-ны байдлаар мах 202.1 тн, гурил 114.1 тн, гурилан бүтээгдэхүүн 21.2 тн, төрөл бүрийн будаа 43.2 тн, ургамлын тос 13.2 тн, төмс 27423.9 тн, хүнсний ногоо 2049.8 тн, элсэн чихэр 24.6 тн, давс 9.1 тн буюу **нийт мах 19 хоног, гурил 13 хоног, төмс 3427 хоног, хүнсний ногоо 87 хоногийн тус тус нөөцтэй байна.**

Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд 2020 оны жилийн эцсийн байдлаар аудит хийсэн дүнг ХХААХҮЯ-ны ЖДҮ газарт хүргүүллээ. Үүнд: Нийт эргэлтийн хөрөнгө 9.4 тэрбум төгрөгт хүрч 8.5 тэрбум төгрөгийн авлага эзэлж байгаас 2.1 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн. Хугацаа хэтэрсэн 3.7 тэрбум

төгрөгийн зээлээс шүүх прокурорын байгууллагад 333 иргэний 1.2 тэрбум төгрөгийн зээлийн материалыг шилжүүллээ.

Монголбанкны зээлийн мэдээллийн санд “Сум хөгжүүлэх сангийн бүртгэл, хяналт, нэгтгэлийн систем”-д 22 сумын 1671 зээлдэгчийн мэдээллийг дахин баталгаажуулан тулгалт хийгдлээ.

“Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль”-ийн 20.2, “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.8-д заасны дагуу жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын бүртгэл статистакийн мэдээллийн тогтолцоотой болох, олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор аймгийн татвар төлөгч 888 аж ахуйн нэгжийн мэдээллийг бүртгэлжүүлж, ажлын явц 80 хувьтай байна.

6. Стандарт, хэмжил зүйн чиглэлээр:

6.1. Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт ажлын хүрээнд: Тохирлын гэрчилгээ шинээр авах буюу сунгуулахаар хүсэлт ирүүлсэн 11 аж ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамруулж, баталгаажуулалтын зөвлөлийн 03 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн 11 аж ахуйн нэгж иргэний 7 хүнсний дэлгүүр, 2 нийтийн хоол, 2 амралтын газрын үйлчилгээнд тохирлын гэрчилгээ хэрэглэх эрхийг 1-2 жилийн хугацаагаар олгох шийдвэр гаргалаа. Стандартын мэдээлэл, лавлагааны үйлчилгээг 3 иргэн, ААН-д хүргэсэн байна.

6.2. Хэмжил зүйн лаборатори: Хэмжил зүйн лаборатори нь Зуунмод, Алтанбулаг сумдын Эрүүл мэндийн төв, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн 18 жин 3 туухай нийт 21ш хүндийн хэмжих хэрэгслийг баталгаажуулсан. Эзэлхүүн зарцуулалтын төрлөөр “Гүн Зэгэстэй” ХХК-ийн Сэргэлэн сум, Сэргэлэн сумын 4-р зөрлөг, Аргалант сумын ШТС, “Ай Си Ай Си” ХХК-ийн Аргалант сумын ШТС-уудад ээлжит шалгалт баталгаажуулалтын ажлыг хийж түгээгүүрийн хошуу -17ш, мерник -4ш, Сүмбэнметр -4ш шалгаж баталгаажуулан нийт 523.000 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. УБЦТС ХХКомпанитай байгуулсан гэрээний дагуу Зуунмод сумын айл өрх аж ахуй нэгжийн нийт 257ш 1фазын цахилгаан тоолуурыг шалгаж баталгаажууллаа.

7. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

7.1. Орчны бохирдолын талаар: Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/428 дугаар тушаалын дагуу Аюултай хог хаягдлын үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, ААН байгууллагыг бүртгэлжүүлэх ажлын хүрээнд 27 сумын эрүүл мэндийн төв, уул уурхай 34 аж ахуй нэгж байгууллагын мэдээллийг загвар маягтын дагуу бүртгэлжүүлж, мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулан ажиллалаа. Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын 07/194 дугаар чиглэлийн дагуу сумдад гол мөрөн уст цэгүүдийг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, 95 албан байгууллагын 1248 иргэдийн оролцоотой 428,7 тн хог хаягдал, 484 сэг зэмийг цэвэрлэж, 2,3 сая төгрөгийг зарцууллаа.

7.2 Усыг хамгаалах, зүй зохистой ашиглах ажлын хүрээнд: Дэлхийн усны өдрийг тохиолдуулан хүүхэд залуучууд, гэр бүлийн дунд 3 төрлийн тэмцээн уралдааныг Төв-Чандмань ДЭХГ, Ус цаг уур, орчны шинжилгээний газар, Зуунмод сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж, Бага насны хүүхдүүдийн дунд “Ус дэлхий бид гурав” дууг хэн сайн дуулах вэ?, дунд ангийн сурагчдад “Усны үнэ цэнэ” гар зургийн уралдаан, ахлах ангийханд “Таны хувьд ус ямар үнэ цэнэтэй вэ” сэдэвт ЭССЭ бичлэгийн уралдааныг тус тус зарласан. Уралдаанд оролцогчдоос нийт 23 бүтээл ирж, төрөл тус бүрт 3 байрыг шалгаруулан өргөмжлөл, гарын бэлгээр урамшууллаа.

7.3. Уул уурхай, хяналт шалгалтын хүрээнд: Ковид-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 3-р сарын 22-ноос 4 хоногийн хугацаатай хяналт шалгалтыг Заамар суманд хийж гүйцэтгэв. Шалгалтаар 15 аж ахуйн нэгж хамрагдаж 5 аж ахуйн нэгжид тус бүр 1.0 сая төгрөгийн торгууль 3 аж ахуйн нэгжид хугацаатай албан шаардлага хүргүүлэн ажиллав.

7.4. Аялал жуулчлалын чиглэлээр: БОАЖЯамны дэмжлэгтэй lhotel.mn, Feelmongolia хамтран “Хямд амар” цахим үзэсгэлэнг 2 үе шаттайгаар 01.27- 03.31-ны өдрүүдэд зохион байгуулагдаж байна. Үзэсгэлэнд Төв аймгаас Монгол улсын заан Б.Батмөнх, Э.Дашням нар оролцон ерөнхий мэдээлэл хийж, Мандала ресорт, Монголын нууц товчоо, Нархан гэр бүлийн амралт, Магнолиа ресорт, Дөрвөн улирал амралтын газрууд нэгдээд байна.

8. Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр:

8.1. Урьдчилан мэдээлэх: Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7, 10 хоног тутмын цаг агаарын тойм мэдээг тус тус гаргаж, И-мэйлээр дамжуулж, www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд И-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил

тасралтгүй хийгдэж, төв талбай болон байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна. 03 дугаар сарын 02, 12, 13, 14-нд Төв аймгийн нутгаар цас орж, цасан шуурга шуурахыг анхааруулах болон сэрэмжлүүлэх мэдээг 12-48 цагийн өмнө 4 удаа нийт 28 635 хэрэглэгч (малчид, ард иргэд)-ийн гар утсанд Багц мессежээр мөн www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан үйлчиллээ.

8.2. Байгаль орчны шинжилгээний лаборатори: Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 03 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт 39 удаа ажиглалт хийсэн ба хүхэрлэг хийн дундаж агууламж 0.009 мг/м3 азотын давхар ислийн дундаж агууламж 0.007 мг/м3 үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүхэрлэг хийн дундаж агууламж 0.001 мг/м3-ээр, нэмэгдсэн азотын давхар ислийн дундаж агууламж 0.001 мг/м3-ээр буурсан үзүүлэлттэй байна.

8.4. Ус судлалын салбар: Төв аймгийн нутаг дэвсгэрт 7-н ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2021 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар усны түвшин: Хэрлэн голын Хэрлэн-Мөнгөнморьт харуулд -197 см, Туул гол Туул-Алтанбулаг харуулд -574 см, Туул-Лүн харуулд-116 см, Туул-Заамар харуулд-141 см тус тус байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Туул-гол 2-21 см-ээр их, Хэрлэн гол Хэрлэн-Мөнгөнморьт харуулд 97 см-ээр их, Хэрлэн-Хонгон харуул, Сөгнөгөр голууд ёроолдож хөлдсөн байна. Хэрлэн, Туул, Сөгнөгөр голууд нь 35-150 см-ийн зузаан мөсөн бүрхүүл үүссэн ч мөсний зузаан харилцан адилгүй, цаг агаар дулаан байгаа учир мөсөн дээгүүр тээвэр хийхэд цөмрөх аюултай тул мөсөн дээгүүр зорчихгүй байхыг анхааруулж, www.tuv.tsag-agaar.gov.mn цахим хуудсаар мэдээллээ.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны тухай мэдээллийг танилцууллаа.

2. Алдарт эхийн 1, 2 дугаар одон шинээр авах 27 сумын 396 эхийн материалыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас хүлээн авч, баримт бичгийн бүрдүүлэлтэд хяналт хийж, шаардлага хангасан 391 эхийн материалыг Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.

Боловсролын салбар:

1. БСУГ, НТБТ, Музей, МТТ-ын албан хаагчид “Ахисан шатны жендерийн дүн шинжилгээ” цахим сургалтад хамрагдаж “Сертификат” авлаа.
2. СӨБ болон ЕБС-ийн багш нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор БСУГ-ын газрын мэргэжилтэн, багш нараас бүрдсэн 13 мэргэжлийн бүлэг үүсгэн, нийт 350 орчим багш ажиллагсдыг хамруулан ажиллаж байна.
3. Аймгийн ЗД-ын 2021 оны 3 сарын 10-ны А/55 захирамжаар танхимын сургалтаа 3 сарын 15-аас эхлүүлэхээр шийдвэрлэсэн боловч цаг үеийн нөхцөл байдлаас хамааран зарим сургуулиуд хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх боломжгүй болоод байна.
4. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хэрэгцээний судалгаа нэгтгэж БШУЯ-нд хүргүүллээ.
5. Улсын олимпиадыг зохион байгуулах нийтлэг журмын төсөлд 30 сургуулийн 512 багшийн саналыг нэгтгэн БШУЯ-нд хүргүүллээ.
6. БШУЯ-ны 661 дугаар тоот хавсралт “Ариун цэврийн байгууламжийн судалгааг” аймгийн 27 сумын Ерөнхий боловсролын 31 сургууль, 29 дотуур байрнаас авч нэгтгэж БШУЯ-нд хүргүүллээ.
7. ЕБС-ийн “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний дотоод хяналтын журам”-ын төсөлд хүргүүлэх саналыг 29 дотуур байрны ахлах тогооч нараас авч нэгтгэн БШУЯ-нд хүргүүлэн ажиллалаа.
8. Сумдын соёлын төвийн эрхлэгч, сум сургууль, МСҮТ-ийн номын санч нарт 2021.03.25-наас 26-ны өдөр мэргэжил арга зүйн чадавхижуулах сургалтыг “**Соёлын үйлчилгээг цахимаар хүргэх**” сэдвийн хүрээнд цахимаар зохин байгуулж 27 сумын албан хаагчид бүрэн хамрагдлаа.

Насан туршийн боловсрол төв:

9. НТБТ-ийн нэгжийн багш нар Амьдрах ухааны 6 сэдвийн дагуу бүсчилсэн сургалтуудыг зохион байгуулан сум болон аймгийн пэйж хуудас дээр байршуулан ажиллаж байна.

10. Насан туршийн боловсролын үндэсний төвөөс зохион байгуулсан Санхүүгийн боловсрол олгох сургалт, Эрх зүйн боловсрол олгох сургалтад нэгжийн багш нарын хамт хамрагдсан.

Монгол туургатан театр:

1. Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран “Эх орончдын баяр”-ын арга хэмжээг зохион байгууллаа.
2. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах баярын өдөрт зориулан “Шүтээн-2” цахим тоглолтыг зохион байгуулж аймгийн Төв телевиз, Монгол туургатан театрын цахим хуудсаар үзэгчдийн хүртээл болголоо.

Нийтийн номын сан:

1. Их зохиолч Д. Нацагдоржийн 115 жилийн ойг тохиолдуулан утга зохиолоор дамжуулан, иргэд, хүүхэд, залуучуудын гоо зүй, ёс суртахууны мэдлэг, боловсролыг ахиулах зорилгоор амьдрал, уран бүтээлийг байгууллагын “Facebook” пейж хуудсанд цувралаар 8 мэдээ мэдээллийг 1516 иргэдэд хүргэсэн байна.

2. Орчин үеийн утга зохиолыг үндэслэгч их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 115 жилийн ой, “Дэлхийн яруу найргийн өдөр”-ийг тохиолдуулан аймгийн Нийтийн номын сан, аймгийн Утга зохиолын нэгдэл хамтран ЕБС-ийн 9-12 ангийн сурагчдын дунд “ГАН ҮЗЭГ-2021” яруу найргийн уралдааныг зохион байгуулж байна.

3. Номын сангийн сан хөмрөгт байгаа уран зохиол, мэргэжлийн болон хүүхдийн зохиолыг төрийн албан хаагч нарт дотоод удирдлагын цахим системээр даваа гараг бүр танилцуулж, 3 дугаар сард нийт 9 номын танилцуулга хүргэсэн байна.

Музей:

1. Төв музейн үзүүллэгийн 7 танхим болон сан хөмрөгөөс холбогдох үзмэрийн зургаар 3-р сарын 22-26 ны өдрүүдэд Виртуал музей-цахим музейн үзэсгэлэнг Телескоф Интертаймэнт ХХК-аар хийлгэж бэлэн болголоо. Уг цахим үзэсгэлэнг 4-р сараас Музейн вэб, пэйж хуудсаар иргэдэд хүргэхээр ажиллаж байна.
2. Музейн үзүүллэгийн 4-р танхим буюу Түүхийн танхимын үзүүллэгийг буулгаж, танхимыг засварлах ажил хийгдэж байна.

Биеийн тамир спортын газар:

1. ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг БТСУХ-ноос зохион байгуулж буй цахим гүйлтйн арга хэмжээг сурталчлан удирдамж гарган сум, сургуулиудад хүргүүлэн алхалт гүйлтээр хичээллэгсдэд гарын авлага хүргүүлэн 1500 гаруй хүнийг хамруулснаас цахим гүйлтийн апплекшнийг 911 хүн гар утсандаа суулган энэ арга хэмжээнд оролцож 24.179 км замыг туулж улсын хэмжээнд 4-р байр эзэллээ.

2. Коронавирус “КОВИД-19” халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, халдвар хамгаалалтын дэглэм, цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах түр журмын дагуу спорт зааланд чөлөөт тоглолт хийх 10 байгууллагатай гэрээ байгуулан 347 иргэнд үйлчилж идэвхтэй хөдөлгөөнд хамруулсан.

3. 03-р сарын 04-ны өдрөөс хойш Коронавирус “КОВИД-19” халдвар Төв аймагт бүртгэгдсэнтэй холбогдуулан “Нэг хаалга-нэг шинжилгээ” аян явагдаж 1, 5, 6-р багийн иргэдээс шинжилгээ авах арга хэмжээг зохион байгуулан заал танхимын цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийг халдвар хамгаалтын дэглэм, дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэсэн.

4. Иргэдийн “Биеийн жингийн индекс”-ийг тодорхойлоход ШШАлба, МСҮТөв, Зуумод сумын ЗДТГ, Хот тохижуулах газар 4 байгууллагын 157 хүний хамруулснаас 71.3% нь илүүдэл жинтэй болон таргалалттай байна.

№	Турнхай	Хэвийн	Илүүдэл жинтэй	Таргалалтын 1-р зэрэг	Таргалалтын 2-р зэрэг	Таргалалтын 3-р зэрэг	Төвийн таргалалттай
	1	32	78	31	13	2	89

ЖИ
-

ийг тодорхойлох ажилд 4 байгууллагын 157 ажилтан албан хаагчдыг хамруулснаас 71.3 % нь илүүдэл жинтэй ба таргалалттай байна. Спорт заал, фитнесийн танхимаар 347 иргэнд үйлчилж, 911 хүнийг хамруулж 24.179 км замыг туулан алхалт гүйгчдийг эрүүл мэндийн цахим гүйлтэнд хамрууллаа.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар:

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ

1. 2021 оны 3-р сарын байдлаар 1892 иргэнд 1486,8 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1272 иргэнд 315,3 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1136 иргэнд 238,4 сая төгрөг, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 2 иргэнд 2,4 сая төгрөг, алдарт эхийн одонтой 9055 эхэд 1189,1 сая төгрөг, 326 ахмад настанд 25,8 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, насны хишиг 5230 ахмадад 431,1 сая төгрөг, 112 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 4,8 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 6680 иргэнд 235,7 сая төгрөг, жирэмсэн 962 эхэд 77,2 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4442 эхэд 628,1 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 303 эх /эцэг/-т 121,4 сая төгрөг, ихэр хүүхэд төрүүлсэн 3 ихэр хүүхэдэд 13,0 сая төгрөг, 33821 хүүхдэд 10015,7 сая төгрөг тус тус олгосон.

Нийгмийн хөгжлийн чиглэлээр

1. Шаардлага хангаагүй 3 сумын 3 эхийн материалыг сумын Засаг дарга, сумын ИТХурлын дарга нарт албан тоотоор тайлбар хариу хүргүүлсэн.
2. Дэлхийн Зөн байгууллагын Төв ОНХөтөлбөрийн төсөл хэрэгждэг 5 суманд \Батсүмбэр, Борнуур, Баянчандмань, Жаргалант, Сүмбэр\ Төв ОНХХ, ХХҮГазрын төлөвлөгөөний дагуу зорилтот бүлгийн “Төгсөлтийн аргачлал” төсөлд хамрагдаж буй 100 иргэнд “Өрхийн санхүүгийн орлого зарлагын бүртгэл” цахим сургалтыг Элит сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан. Үүний үр дүнд өрхийн орлого зарлагаа зөв хөтөлж сурах, өрхийн төсвийн тухай ойлголт мэдээлэлтэй болсон.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын хуралдаан 1 удаа хуралдаж тус хурлаар 6 хүүхдийн асаргаа хөгжлийн бэрхшээлийг тодорхойлсон байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүүхдийн мөнгөө, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний хүрээнд:

1. Өрхийн мэдээллийн нэгдсэн санд шинэ төрсөн 137 хүүхдийг бичиг баримтад үндэслэн бүртгэж хүүхдийн мөнгөнд хамруулсан. Улсын хэмжээнд 0-18 хүртэлх насны 33821 хүүхэд 10015,7 сая төгрөг зарцуулсан.
2. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 1146 өрхийн 6680 иргэнд 235,7 сая төгрөгийг зарцуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 43 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 4 ажил олгогч байгууллага, иргэн, 94 сул чөлөөтэй ажлын байр, 47-н ажилд зуучлагдсан иргэн, 9 шинэ ажлын байрны мэдээллийн санд оруулж ажиллалаа. Ажилгүйдлийн тэтгэмжинд хамрагдах 11-н иргэнд бүртгэлд хамрагдсан тодорхойлолтыг Нийгмийн Даатгалын Хэлтэст гаргаж өгсөн. Түр ажлын байранд ажилласан 115 иргэдийн мэдээллийг сумдаас авч мэдээллийн сан үүсгэлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан:

Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 11970,2 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрт Уулс Заамар ХХК-аас 7190,8 мянган төгрөг нийт 19160,0 мянган төгрөгийг төвлөрүүллээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр:

“Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага-2020” улсын уралдаанд дулаан үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Баян-Өнжүүл сумын Эл Си Би ХХКомпани, цементийн үйлдвэрлэл эрхэлж буй Сэргэлэн сумын Мөнхийн баян гал ХХКомпани, цахилгаан үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч УБ Цахилгаан түгээх төвийн Зуунмод Түгээх төв, МБСБайгууллагын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Эрдэнэ сумын Эрдэнэ МСҮТөв зэрэг

байгууллагуудаас шаардлага хангасан материал ирүүлснийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд уламжиллаа.

Тус төвөөс БНСУ-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн агентлагтай хамтран /КОША/ "Ковид-19 халдварын үед ажлын байранд аюулгүй ажиллах, ажилтны эрүүл мэндийг хамгаалах нь" сэдэвт цахим сургалтыг зохион байгуулахад ХХҮГазрын ХЭХэлтсийн мэргэжилтнүүд болон ХАБЭА-н зөвлөлийн гишүүдийг оролцуулж, мэдээлэл хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын хэлтэс:

1. “Нийгмийн даатгалын тухай хууль”-д заасан болзол хангаж шинээр тэтгэвэр тогтоолгосон 115, ажилласан жил нэмүүлэх, тэтгэврээ өөрчлөн тогтоолгосон 24, нийт 139 хувийн хэрэг шалгаснаас 27 хувийн хэрэгт бүрдүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу, шаардлага хангаагүй зөрчил илэрснийг арилгуулан, зөрчилгүй болгосны дараа тэтгэврийг хянаж тэтгэвэр авах эрхийн нөхцөлийг ханган ажиллалаа.
2. Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын хурлыг 2 удаа 19 цаг хуралдаж, нийт 160 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 8 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, 141 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 11 иргэнийг цуцалсан байна.
3. Нийгмийн даатгалын хэлтсийн даргын баталсан “Орон тооны бус зөвлөлийн дүрмийн хэрэгжилт, зөвлөлийн гаргасан тогтоолын үндэслэлд хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийн дагуу шалгалтад сумдад байгуулагдсан орон тооны бус зөвлөлийн даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг тогтоож гаргасан 2020 оны нийт 242 тогтоолыг хамрууллаа. Архуст, Баянцагаан, Баянчандмань, Борнуур, Дэлгэрхаан, Эрдэнэ сумын байцаагч нар шалгуулах орон тооны бус зөвлөлийн баримт бичиг, материалаа ирүүлээгүй, Баян, Баянхангай, Жаргалант, Сүмбэр сумын байцаагч нар орон тооны бус зөвлөлийн баримт бичиг, материал бүрдүүлэлт нотлох баримтын шаардлага хангаагүй, нэмэлт материал бүрдүүлэх шаардлагатай байна.
4. Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 247 дугаар тогтоол, НДЕГ-ын даргын А/34 дугаар тушаалын дагуу 500 гаруй ажил олгогч, 5400 орчим сайн дурын даатгуулагчдад шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
5. 2021 оны эхний хоёр сарын байдлаар ажил олгогчдод 186,5 сая төгрөг, сайн дурын даатгуулагчдад 136,5 сая төгрөгийн шимтгэлийн хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлээд байна.
6. Аймгийн хэмжээнд жирэмсэн амаржсны тэтгэмж 29 иргэний 56.7 сая, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 23 иргэний 4.7 сая, ажилгүйдлийн тэтгэмж 29 иргэний 16.8 сая, ҮОМШӨ-ний тэтгэмж 1 иргэний 1.5 сая нийт 79.7 сая төгрөг, 15692 тэтгэвэр авагчдад 6050,8 сая төгрөгийн тэтгэвэр олгон ажилласан. Эрүүл мэндийн даатгалд 359 малчин хамрагдаж 10.5 сая, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн 18 даатгуулагчийн 10.1 сая, мэргэжлийн сургуульд суралцагч 28 даатгуулагчийн 0.508 сая нийт 821 даатгуулагчийн 21.1 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэн ажилласан.
7. Аймгийн хэмжээнд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа 25 иргэн, цалингийн лавлагаа 18 иргэн, аймаг дүүргийн хүсэлтийн дагуу 20 лавлагаа, QR кодоор 16 иргэн, нөхөн даатгалын лавлагаа 5 иргэн нийт 85 иргэнд архивын лавлагааг олгон ажиллалаа.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар:

Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

1. Сумдын “Хамтарсан баг”-ийн гишүүн Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Боловсролын нийгмийн ажилтан нарт эрсдэлт нөхцөл байгаа хүүхдийн сэтгэл зүйн байдалд дүн шинжилгээ хийх, гэр бүл, хүүхдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдлэг, арга зүйг олгох, мэргэжлийн тусламж үйлчилгээг чанаржуулах, үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор “Эрсдэлт гэр бүлтэй ажиллах арга зүй практик” сэдэвт 2 өдрийн цахим сургалт зохион байгуулж сумдын “Хамтарсан баг”-ийн нарийн бичгийн дарга, Нийгмийн бодлогын мэргэжилтэн-10, Боловсролын нийгмийн ажилтан -6, ГБХЗХГ-ын дарга, мэргэжилтэн-4, ЭМГ-ын сэтгэл зүйч-1, Дэлхийн зөн Төв ОНХ-ийн ажилтан-1, нийт 22 албан хаагч хамрагдсан.

2. Дэлхийн Зөн Төв ОНХ-тэй хамтран “Оролцоод хөгжье” клубыг удирдан чиглүүлэгч багш бэлтгэх 2 өдрийн цахим сургалт зохион байгуулж, 18 сургуулийн Нийгмийн ажилтан, Насан туршийн боловсролын багш 2, дотуур байрны багш 2, ерөнхий эрдмийн багш 14, ГБХЗХГ, Дэлхийн зөнгийн олон улсын байгууллагын дарга, мэргэжилтэн нийт 40 албан хаагч хамрагдав.

Гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

1. Аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран Цагдаагийн газрын түр саатуулах байранд гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний зөрчлөөр 7-30 хоног баривчлагдсан 25 хүмүүжигчид “Зан үйлд нөлөөлөх сургалт” зохион байгуулж, хамтран ажиллалаа.
2. Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 03 дугаар сарын 18-ны өдөр охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох зорилготой өрнүүлдэг “НЭГ ТЭРБУМААРАА ТЭМЦЬЕ” олон улсын хөдөлгөөний талаар мэдээлэл хүргэж, “Бидний дуу хоолой” бүтээлч дэвтрийн танилцуулга сургалт зохион байгуулж, “Гэр бүлийг дэмжих” хөтөлбөрт хамрагддаг Зуунмод сумын 5 багийн 8 эмэгтэй хамрагдав.
3. “Хөөрхөн зүрх” төрийн бус байгууллагатай хамтран 03 дугаар сарын 24-ний өдөр “Сургууль ба Охидын үзлэг” хэлэлцүүлэг цахимаар зохион байгуулан аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Нэгдсэн эмнэлэгийн мэргэжилтнүүд болон Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн Төв аймаг дахь салбарын менежер, хүний эрхийн үндэсний комиссын шинжээч, сургуулийн Нийгмийн ажилтнууд зэрэг нийт 13 албан хаагч оролцлоо.
4. Аймгийн Засаг даргын 2019 оны “Гэр бүлийн өдрийн тухай” А/229 дугаар захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд 3 дугаар сарын гэр бүлийн өдрийг хүүхэд багачуудын хөгжлийг дэмжих, эцэг эхчүүдийн хүүхдэдээ зарцуулах цагийг нэмэгдүүлэх, хамтдаа бүтээж, хөгжихөд дэмжлэг үзүүлэх, гэр бүлээрээ чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, цахим хэрэглээг зөв зохистой ашиглах, зөв дадал хэвшилд суралцуулах зорилгоор **“Бид гэр бүлдээ зөв дадал хэвшилтэй”** уралдааныг зарласан. Уралдаанд 19 хүүхдийн бичлэгийг цахимаар хүлээж авч, шагналт байруудыг шалгаруулж, урамшууллаа.

Залуучуудын хөгжил, нийгмийн оролцоог хангах чиглэлээр:

1. “GOOD DEEDS DAY”- Дэлхийн сайн үйлсийн сарын аяны хүрээнд Дэлхийн Зөн Төв ОНХ-тэй хамтран **“Сайн дурын үйл ажиллагаагаар дамжуулан хувь хүнд хүрэх үр нөлөө”** сэдэвт цахим сургалт зохион байгуулж, сайн дурын идэвхтэн болон өсвөр үеийн 39 залуусыг хамрууллаа. Үндэсний хэмжээнд өрнөж буй “Good Deeds Day” аяныг Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх Нөлөөлөл клубын гишүүд орон нутагтаа эхлүүлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбар:

1. Аймгийн хэмжээнд 2021 оны 02 сарын байдлаар 205 эх төрж өнгөрсөн мөн үеийнхээс 7 тохиолдлоор өссөн ба 203 нярай бүртгэгдсэн байна. Нийт 39432 үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 11591, амбулаторийн үзлэг 19803, идэвхитэй хяналтын 4280 үзлэг хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 2720 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 26.51%, осол гэмтлийн дуудлага 1.88%-ийг эзэлж байна. Стационарт 1916 хүн эмчлэгдэн нийт 14514 ор хоног ашигласан байна. Дундаж ор хоног 7,6 байна.
2. Төв аймагт 2021.03.06-ны өдөр Коронавируст халдварын батлагдсан тохиолдол анх удаа бүртгэгдэж, 2021.03.29-ний өдрийн байдлаар шинээр 80 тохиолдол бүртгэгдэж, нийт 147 тохиолдол батлагдлаа. Өндөр эрсдэлтэй 1-р хавьтал 386, бага эрсдэлтэй 1-р хавьтал 504, 2-р хавьтал 1187 иргэнийг тандалт судалгаанд хамруулсан, тусгаарлан ажиглах байранд 232 иргэн, гэрийн ажиглалтад 650 иргэн, CLIX GPS SYSTEM-ийн хяналтаар 319 иргэнийг тус тус хянасан.

Шинээр батлагдсан 80 тохиолдлын тархвар зүйн судалгаа хийгдэж байна. 2021.03.06-ны өдрөөс хойш ЗӨСҮТ-ийн вирус судлалын лабораторид ПГУ шинжилгээнд 8844 сорьц зөөвөрлөсөн байна. Аймгийн хэмжээнд 27 сумын Эрүүл мэндийн төв, шалган нэвтрүүлэх 2 пост дээр лабораторийн түр цэг байгуулан түргэвчилсэн оношлуураар нийт 8156 иргэнээс шинжилгээ авахад сул эерэг 2, эерэг 11 илэрсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 52, Аргалант

- сумын Эрүүл мэндийн төвд 1, Улаанбаатар хотод 14 өвчтөн эмчилгээнд хамрагдсанаас, 20 иргэн эмчлэгдэн эмнэлгээс гарч одоогоор нийт 47 иргэн эмчлэгдэж байна.
3. 2021 оны 03 дугаар сарын 08, 09-ны өдөр Зуунмод суманд “Нэг өрх-нэг шинжилгээ” арга хэмжээ зохион байгуулж нийт 14.7 сая төгрөгийн санхүүжилтээр хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, эмнэлгийн хэрэгсэл, 1.5 сая төгрөгийн санхүүжилтээр пос машин аймгийн Засаг даргаас шийдвэрлэсэн. PCR шинжилгээнд нийт 4531 иргэн хамруулснаас Коронавируст халдварын 4 тохиолдол илрүүлсэн.
 4. Нийт 54 голомтод эцсийн халдваргүйтгэл хийсэн. Батлагдсан тохиолдлын гэр, тусгаарлан ажиглах байр, тээврийн хэрэгсэл, 17 албан байгууллага, хог хаягдлын цэг зэрэг нийт 19143 м² талбайд хийж гүйцэтгэлээ.
 5. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсэг томилон, хадгалах, түгээх, дархлаажуулалт хийх байнгын болон түр цэг ажиллуулах бэлтгэл ажлыг ханган, 1000 хүн/тун вакцин татан авалт хийлээ. Дархлаажуулалтад хамрагдах иргэдийн судалгаа гарган, төлөвлөгөөний дагуу эхний ээлжийн дархлаажуулалтад Зуунмод, Эрдэнэ сумын 24 байгууллагын 706 албан хаагчийг вакцины 1-р тунд хамрууллаа.
 6. Угтаалцайдам, Баянцагаан, Өндөрширээт сумын вакцины хөргөгчийг шинэчлэхээр тендер зарлагдаж дууссан. ХӨСҮТ-д асуудал дэвшүүлснээр Баянчандмань сумын ЭМТ-ийн вакцины хөргөгч шинэчилсэн.
 7. Нэгдсэн эмнэлэг, 26 сумын эрүүл мэндийн төвд 2021 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурын 35 багц тендер зарлаж, 23 багцад шалгарсан 12 компанитай цахимаар гэрээ байгуулан ажиллаж байна. Үлдсэн 12 багцад төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу дахин нээлттэй тендер шалгаруулах журмаар тендерийг 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зарласан.
 8. 2021 оны эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөлийн нэгдүгээр хуралдаанаар 26 сумын Эрүүл мэндийн төвд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэглэл, халдваргүйтгэлийн бодисын нөөц бүрдүүлэх зорилгоор эмийн эргэлтийн сангийн хөрөнгөөс 2.0 сая төгрөг зарцуулах эрхийг сумын эрүүл мэндийн төвийн дарга нарт зөвшөөрч нийт 26 суманд 52.0 сая төгрөг шийдвэрлэсэн.
 9. ЭМЯ-аас 26.6 сая төгрөгийн үнэ бүхий коронавируст халдварын үед хэрэглэгдэх вирусын эсрэг эмийг аймгийн нэгдсэн эмнэлэгт нийлүүлж эмчилгээнд хэрэглэж байна. 3 төрлийн вирусын эмийн нөөц бүрдүүлсэн.
 10. ЭМЯ-аас 4 нэр төрлийн 25.9 сая төгрөгийн нэг удаагийн хамгаалах хэрэгслийн татан авалт хийсэн.

Сургалт, сурталчилгаа:

11. Ковид-19-ын эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагаа зохион байгуулах чиглэлээр 5 удаагийн сургалт хийж, сумдын онцгой комисс, гишүүд, эрүүл мэндийн байгууллагын албан хаагчид нийт 327 хүн хамруулсан. Эрүүл мэндийн байгууллагууд ажлын байрны сургалтыг 10 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 189 эмч, эмнэлгийн ажилчид хамрагдсан.
12. ЭМХТөвөөс зохион байгуулсан “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, сайжруулах чиглэлээр хийсэн цахим сургалт, хэлэлцүүлэг”-т хамрагдав. ЭМЯамнаас зохион байгуулсан “Ковид-19 цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед эмнэлгийн ор дэлгэх тухай” цахим сургалтад хамрагдав.
13. АНЭ, өрх, сумын Эрүүл мэндийн төвийн нийт 212 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 2 удаа цахим хурал зохион байгуулж, цаг үеийн мэдээлэл, цаашид анхаарах асуудал дээр зөвлөмж өгч ажилласан
14. Аймгийн хэмжээнд коронавируст халдварын нөхцөл байдлын талаарх мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар тогтмол хүргэж байна
15. Коронавируст халдвараас сэргийлэх талаар ЭМЯ-аас гаргасан 9 төрлийн зөвлөмжийг постер хэлбэрээр бэлтгэж, нийт 310 ширхгийг хэвлүүлэн Баруун Зуунмод өрхийн эрүүл

мэндийн төвд өглөө. Үүнээс 7 зөвлөмжийг TBS телевизийн цахим хуудсаар шторк болгож нэвтрүүлээ.

Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө эхний 2-р сарын байдлаар орон нутаг 665.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 807.4 сая төгрөг төвлөрүүлж 121.3 хувьтай, 141.8 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давж биелсэн байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 2884.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2219.4 сая төгрөг төвлөрүүлж 77.40 хувьтай, 664.5 сая төгрөгөөр тасарсан. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 306.9 сая төгрөгөөр тасарч, 92.8 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Аргалант, Батсүмбэр, Баянхангай, Жаргалант, Сэргэлэн зэрэг 5 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Архуст, Баянжаргалан, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Заамар, Өндөрширээт, Сүмбэр, Угтаал, Эрдэнэсант, Зуунмод зэрэг 12 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баян, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянцагаан, Бүрэн, Дэлгэрхаан, Мөнгөнморьт, Цээл, Эрдэнэ зэрэг нийт 9 сум байгаа ба 3 шатны орлогын төлөвлөгөө тасалсан Лүн сум байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Сумдад 2021 оны 2 сарын байдлаар нийт 12055,7 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл:

Боловсрол шинжлэх ухааны сайдын багцаас 5929,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Үүнд:

-Ерөнхий боловсролын сургуулиудад 3985,5 сая төгрөг

-Хүүхдийн цэцэрлэгт 1944,0 сая төгрөг тус тус олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас 1528,3 сая төгрөгийг олгосон. Үүнд:

-Сумдын эрүүл мэндийн төвд 1459,1 сая төгрөг

-Өрхийн эмнэлэгт 69,2 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 107.6 сая төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 52.7 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 4437,6 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Үүнээс:

-Сумдын ИТХ, ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 3068.2 мянган төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 1369,4 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

Өр, авлагын талаар:

2021 оны 2-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгуулагууд нийт 196385,1 мянган төгрөгийн авлага, 227086.3 мянган төгрөгийн өглөгтэй байна. Нийт өглөгийн 45777,7 мянган төгрөг буюу 20.1 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг 41712,9 мянган төгрөг буюу 18.4 хувь нь цалингийн өглөг, 6128.3 мянган төгрөг буюу 2.7 хувь нь НДШимтгэлийн өр, 18597.1 мянган төгрөг буюу 8.2 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, үлдсэн 114870,3 мянган төгрөг буюу 50,6 хувийг бусад өр эзэлж байна

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Төв аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан дэд хөтөлбөрт 2020 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 89.52 хувьтай үнэлж аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Засгийн газрын цахим сан /www.new.unelgee.gov.mn /-д тайлагналаа.

Хэлтсийн албан хаагчид “Ахисан түвшний жендерийн дүн шинжилгээ” цахим сургалтад хамрагдаж түвшин тогтоох шалгалтыг амжилттай өгч сертификадаа авлаа.

Батлагдсан бодлогын баримт бичгүүдийг эмхэтгэж тохимол болгож хэлтэс, агентлаг, харьяа байгууллага, сумдад хүргүүлээд байна.

Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Төв аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө, “Хүний хөгжил-эрүүл мэндийг дэмжих” урианы жилийн ажлын төлөвлөгөө, Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүллээ. Үүнд:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

Төв аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

Төв аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

Төв аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт

Засгийн газрын гишүүн Төв аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний зүргийн биелэлт

Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт – Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт Байгууллагын ил тод байдлын үнэлгээ Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ

Төв аймгийн засаг даргын тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн

Үзүүлэлт		Хувь 100.0	Жин 0.6	Оноо 5.00
1		2	3	4
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	97.16	0.582	4.85
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	86.00	0.516	4.30
	3. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	93.60	0.561	4.68
	4. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	95.53	0.573	4.77
	5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	78.0	0.468	3.9
Дундаж үнэлгээ:		90.06	0.54	4.50
Үзүүлэлт		Хувь 100.0	Жин 0.2	Оноо 5.00
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	95.53	0.191	4.78
	2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	96.09	0.192	4.80
	3. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	85.71	0.171	4.28
Дундаж үнэлгээ:		92.44	0.184	4.62
Үзүүлэлт		Хувь 100.0	Жин 0.2	Оноо 5.00
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	97.86	0.195	4.89
	2. Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ	92.78	0.186	4.63
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	-	-	-
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-	-	-
Дундаж үнэлгээ:		95.32	0.190	4.76

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ:**Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:**

2021 оны 03 дугаар сарын 25-ны байдлаар Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад сумдын Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, Мал хамгаалах сангийн 2017-2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, Зуунмод сумын хот тохижуулах газар, БОАЖГ, Улсын бүртгэлийн хэлтсийн 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 171,305.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 48,535.9 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт, 122,769.4 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага тогтоож ажиллав. Улсын байцаагчийн акт, албан шаардлагын биелэлт гаргах хугацаа болоогүй байна.

Найм. Цэргийн штабын хүрээнд:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны А/98 дугаар захирамжийн дагуу “Монгол цэргийн өдөр” орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд тусгай төлөвлөгөө гарган батлуулж, COVID-19 цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан цахим хэлбэрээр орон нутагтаа зохион явууллаа. “Монгол цэргийн өдөр” орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлсэн тухай мэдээг “Соёмбо” сонинд явуулж, мөн орон нутгийн 2 телевиз, хэвлэл мэдээлэлийн сайтуудаар олон түмэнд хүргэж, түүхт 100 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүллээ.

2. Нийгмийн хамгааллыг сайжруулах ажлын хүрээнд 03 дугаар сарын 17-ны өдөр Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлтэй хамтран Төв аймгийн Зуунмод сумаас хугацаат цэргийн алба хааж байгаа хоёр цэргийн алба хаагчын ар гэрт болон зорилтот бүлгийн хоёр өрхөд хүнсний багц болон түлээ нүүрсийг гардуулан өглөө. Мөн тухайн айлынхаа хашааг янзалж ариутгаж өгсөн. Зэвсэгт 016 дугаар нэгтгэлд алба хааж байгаа хоёр хугацаат цэргийн алба хаагчийн ар гэрт захирагч нь өөрийн биеэр талархлын захидал гардуулж өгсөн баярт үйл явдал болсон.

Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойн хүрээнд Төв аймагт 1981 оны 03-р сарын 22-ны өдөр төрсөн Баяндэлгэр, Баянчандмань, Дэлгэрхаан, Зуунмод сумын 4 иргэнд хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг өглөө. Цар тахалын улмаас сум орон нутгийн удирдлагуудаар дамжуулан хүргүүлж ажиллалаа.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар